

ГАРЫН АВЛАГА

**НАЙРУУЛГА  
ЗҮЙ**





Хэвлэлийн Хүрээлэн



Konrad  
Adenauer  
Stiftung

# НАЙРУУЛГА ЗҮЙ

---

Сэтгүүлч таны ширээний ном №7

Энэхүү номыг Конрад-Аденауэр-Сангийн  
дэмжлэгтэйгээр хэвлэв.

Улаанбаатар хот  
2017 он

Хэвлэлд бэлтгэсэн:

З.Энхбаяр  
Ч.Байгалмаа  
Ц.Чимиддондог

Хянан тохиолдуулсан:

М.Мөнхмандах

Хэвлэлийн эх бэлтгэл:

Л.Болортуяа

Хэвлэлийн хүрээлэн

Их тойруу 11Б

Утас/Факс: 350002

Цахим хуудас: [www.pressinst.org.mn](http://www.pressinst.org.mn)

Цахим хаяг: [pressinst@mongol.net](mailto:pressinst@mongol.net)

[pim@pressinst.org.mn](mailto:pim@pressinst.org.mn)

1. Найруулга зүйн тухай үндсэн ойлголт.....	4
2. Найруулгын шаардлага, хэм хэмжээ.....	8
3. Найруулгын алдаа түүнийг ангилах нь.....	11
4. Найруулгын бус алдааны төрөл, хэлбэр.....	22
5. Үг бүтэхүйн найруулгын онцлог.....	26
6. Үг хувилахуйн найруулга түүний онцлог.....	34
7. Үгийн сангийн найруулга ба онцлог.....	44
8. Өгүүлбэрийн найруулгын онцлог.....	56
9. Сэтгүүл зүйн бичлэгийн зарим төрлийн найруулгын онцлог.....	60
10. Ашигласан номын жагсаалт.....	70

# НАЙРУУЛГА ЗҮЙН ТУХАЙ ҮНДСЭН ОЙЛГОЛТ

Сэтгүүлч найруулан бичих арга ухааныг хэр зэрэг эзэмшсэнээс түүний бичсэн бүтээл, нийтлэлийнх нь чанар чансаа хамаардаг. Энэ утгаараа найруулан бичих чадвар бол хэвлэн нийтлэгчдийн заавал эзэмших ур чадварын нэг мөн.

## Найруулга /style/ гэж юу вэ?

Найруулга гэдэг нь уран илтгэх ухаан гэсэн үгнээс гаралтай бөгөөд чухам юуг хэлдэг талаар гадаад, дотоодын хэл шинжлэлийн судлаач, эрдэмтэд өөр өөрийн байр сууриа илэрхийлж, олон янзаар тодорхойлжээ.

Тухайлбал:

*“Найруулга бол бичих арга барил бөгөөд тэр нь зохиогчийн бичлэгийн төрлийн тухайн үеийн онцлогийг илэрхийлнэ.” / П.Гиро /*

*“Найруулга бол түүхийн явцад бүрэлдэн тогтсон, нийт ард түмэн үг ярианы харилцуурын хэрэглүүрийг шилж сонгох, хэрэглэх арга барилыг ухамсарлан мэдсэн, өнгө аяс болон хэлний нарийн ялгамжааг илтгэсэн, хэлний нэгжүүдийг аль болох зохистой хэрэглэсэн, дотоод нэгдэл бүхий хэлний тогтолцоо юм.” / Ц.Сүхбаатар /*

*“Хэлний илтгэх арга барилын тогтолцоог найруулга гэнэ.”*

*/ Ө.Наранбат /*

Эдгээр ишлэлд найруулга гэж чухам юу болохыг янз бүрээр илэрхийлсэн хэдий ч агуулгын хувьд үндсэндээ нэг утга санааг илэрхийлж байна. Бид дээрх эрдэмтдийн тодорхойлолтод үндэслэн найруулга гэдгийг энгийнээр:

*“Санаа бодлоо зөв оновчтой, эмх цэгцтэй, энгийн ойлгомжтой илэрхийлэн бичих аргыг найруулга гэнэ.”* хэмээн тодорхойлж болж байна.

Харин хүн санаа бодлоо бичгээр илэрхийлэхийн тулд юуг найруулан бичиж болох вэ? Харилцааны хамгийн бага нэгж бол өгүүлбэр бөгөөд өгүүлбэрээр санаа бодлоо илэрхийлэх бүрэн боломжтой учраас өгүүлбэрийг зөв найруулж бичнэ.

Өгүүлбэрээс гадна найруулан бичих нэгжид :

- Цогцолбор
- Эх
- Эсээ
- Нийтлэл
- Зохиол зэргийг оруулдаг.

Аливаа найруулгыг үгийн сангийн байдлаас нь шалтгаалан эрхэмсэг буюу дээд найруулга, ерийн буюу дунд найруулга, доромж буюу доод найруулга гэж гурав ангилан авч үздэг.

**1. Эрхэмсэг буюу дээд найруулга:** Бичиг зохиолын хэлний дээд хэм хэмжээнд тохирох хуучирсан үг, шинэ үг, яруу найргийн үг зэрэг эрхэмсэг тансаг үг ашигласан найруулга багтдаг.

**2. Ерийн буюу дунд найруулга:** Энгийн хэл, найруулга.

**3. Доромж буюу доод найруулга:** Этгээд, завхай, бүдүүлэг үг хэрэглэсэн найруулгыг багтаадаг.

Ижил нэг сэдэвтэй эхийг хүн бүр янз бүрээр бичсэн байдаг. Зарим нь тухайн зүйлийг тоочиж, аль эсвэл үйл явдлын өгүүлэмжээр хүүрнэн бас тайлбарлан бичсэн байхад зарим нь өөрийн үзэл бодол, байр сууринаас үнэлж дүгнэсэн, эргэцүүлэн бичсэн байдаг. Хүн хүний юмыг ойлгох ухаарах байдал өөр өөр байдагчлан бодол санаагаа хэлээрээ илэрхийлэх арга хэв маяг, найруулга, ур чадвар, авьяас нь өөр өөр байдаг. Ийм байдлаас үүдэн аливаа зохиомж болон эхийг найруулан бичих арга нь үндсэн дөрвөн хэв маягтай байдаг.



**•Тоочимж:** Юм үзэгдлийн гадаад ба дотоод шинж чанарыг тухайн хам цагт тоочин дурдаж бичсэн эх юм. Гадаад, дотоод, гол хэсэг гэсэн бүтэцтэй. Тоочимж нь тухай юмс үзэгдэл, орон байр, цаг улирлын тухай тодорхой мэдээлэл өгдөг.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Хөдөөгийн байдал шалдар булдар, цагийн байдал ороо бусгаа.  
Элстэй шавар цайдмыг дагаж хааяа нэг хар ...

/Д.Нацагдорж “Хуучин хүү”/

• **Хүүрнэмж:** *Хэрэг явдал, үйл явцыг цагийн дэс дарааллаар эхнээс нь дуустал энгийн хүүрнэн өгүүлнэ. Эхлэл, гол, төгсгөл хэсгээс бүрдэнэ. Үлгэр, домог, тууж, роман, өгүүлэл, намтар, өдрийн тэмдэглэл гэх мэт. Хүүрнэмжээс тухайн үйл явдал, хэрэг явдлын тухай харилцан уялдаатай, дэс дараатай, цогц мэдээлэл олж авдаг.*

**Жишээ нь:**

Уужимхан урт хөндийн эхэн тушаа, хадтай өндөр толгойн энгэрт гурван өвгөн хайлаас холоос сүр бараатай харагдана.

/Н.Банзрагч “Энгэрийн гурван хайлаас”/

• **Эргэцүүлэмж:** *Юмсын учир шалтгаан, бүтэц бүрэлдэхүүн, мөн чанарыг аль нэг талаас нь онцлон тодорхойлж, тайлбарлан бичсэн эх. Агуулга нь баримт жишээ, тооцоо судалгаа, шалтгаан, үр дагавар, дүрэм тодорхойлолтод тулгуурласан байдаг.*

**Жишээ нь:**

Тулганд гал чимээгүй асна. Сэгсүүргэн дээл нөмрөн галын захад суугаа өвгөн гаансаа хаа нэгхэн чимээгүй сорж гал ширтэн бодлогоширно. Ийнхүү анир чимээгүй асдаг гал гагцхүү талын монгол бидэнд л байх агаад галыг шүтэн эцэг өвгөд минь амь зууж, энэ галын дэргэд үр ач нар минь бойжиж, энэ галын дэргэд үлгэр туульс үүх түүх маань зохиогдсон.

/Д.Батбаяр “Аргалын гал”/

• **Тайлбарламж:** *Аливаа юмс үзэгдэл, үйл байдлын учир шалтгаан, шинж чанарыг шүүн тунгааж, баталсан ба үгүйсгэсэн дүгнэлт гарган бичсэн эх юм. Энэ нь баримт, баталгаа, дүгнэлт шаарддаг тул дэвшүүлсэн асуулт баталгаа, дүгнэлт гэсэн хэсэгтэй байна.*

**Жишээ нь:**

Аливаа хэлэнд бодит утга нь идэвхэжсэн, бүхэл гэсэн үндсэн хоёр төрөл байхаас гадна... /Эрдэм шинжилгээний өгүүллээс/

Тухайн эхийн агуулга сэдвээс хамаарч ямар найруулгаар яаж бичих вэ? гэдгээс шалтгаалан найруулгын хэв маягийг сонгох ёстой. Эдгээр хэв маяг нь хоорондоо бичлэг найруулгын өнгө аяс, хэлний онцлогоороо тус тус ялгарч байдаг.

## Найруулга зүй /stylistique/ гэж юу вэ?

Найруулга зүй нь санаа бодол, юмс үзэгдлийг хэлний олон зүйл нэгжийг ашиглан, тухайн учир зорилгод нийцүүлэн хэрхэн яруу, тодорхой илэрхийлэх арга боломж, хэм хэмжээг судлах хэл шинжлэлийн салбар ухаан юм.

*“Найруулга зүйн шинжлэх ухаан нь санаа бодлоо илэрхийлэхдээ тохируулан хэлний аль нэг хэрэглүүрийг төгс төгөлдөр сонгон найруулж чадсан эсэхийг тодруулан судалдаг ухаан”* гэдэг тодорхойлолт түгээмэл байдаг.

Найруулга зүйн ухаан дахь хэлний хэрэглүүрийн хүрээ маш өргөн төдийгүй үг сонгох, яруу хэрэглүүрийг ашиглах, зөв бичих дүрмийн асуудлууд, сэдэв сонгох зэрэг аман болоод бичгийн ярианы бүх хэлбэрүүдийг багтаадаг.







Энэ хэсэгт авианы дуу чимээг илэрхийлэх боломжийг чадамгай ашигласан учир яруу сайхан найруулга болж чадсан харин “тав, тас, хүр” гэснийг хасахад уг өгүүлбэрийн утга, хэм хэмжээ алдагдахгүй боловч уран дүрслэл, найруулгын өнгө аяс нь алга болно.

**Жишээ нь:**

Мориноосоо бууж, жолоогоо сойгоод, тоосонд дарагдсан урд хормойгоороо наранд шарагдсан нүүрнийхээ хөлсийг арчиж, нусаа нийгээд гэрт оров.

**Тэгвэл санаагаа оновчтой, ойлгомжтой илэрхийлэхийн тулд юунд анхаарах вэ?**

Энэ талаар эрдэмтэн судлаачид дараах зүйлсийг зөвлөсөн байдаг.

Найруулга зүйч Р.Жеоржин найруулж сурахад эзэмших хамгийн чухал чанар бол:

- Өгүүлж байгаа зүйл тодорхой
- Үг хэллэг оновчтой
- Үгийн баялаг арвин
- Нуршсан зүйлгүй товчхон
- Өөрийн гэсэн арга барилтай
- Чамирхсан зүйлгүй, энгийн байх гэсэн байдаг бол

Харин эрдэмтэн Г.Сүхбат нар Найруулгын шаардлагыг үзэхдээ:

А: Ерөнхий шаардлага

- Ойлгомжтой
- Үг сонголт сайтай оновчтой
- Товч хураангуй
- Гоо зүй хийгээд учир зүйд нийцсэн

Б: Тусгай шаардлага

- Сонирхолтой
- Яруу сайхан
- Нэгэн загвартай
- Зохиогчийн онцлог, арга барил туссан байхыг зөвлөжээ.

Ингэж хоёр хэсэгт хуваасны учир нь найруулгын бүх л төрөлд тохирч байх үндсэн ерөнхий шаардлага, түүнчлэн албан бичиг, сонин нийтлэл, уран зохиол, шинжлэх ухаан, ярианы зэрэг тусгайлсан, өөрийн гэсэн онцлог бүхий төрөл зүйлд тохирсон тусгай шаардлага байх ёстой гэж үзсэн явдал юм.

Өөрөөр хэлбэл сэтгүүлчдийн хувьд ч ялгаагүй, эхний дөрвөн шаардлагыг бичлэгийн бүх төрөл зүйлд зайлшгүй хангаж ажиллах ёстой аж. Харин яруу тансаг, өөрийн гэсэн өнгө аястай бичих шаардлагыг дүрслэн харуулах, мэдрүүлэх зорилго бүхий сурвалжлага, хөрөг зэрэг төрөл зүйлд биелүүлэх нь чухал байна.

Найруулга зүйн үндсэн шаардлага, эх найруулгын дүрэм горимыг зөрчсний улмаас үүсэх үр дагавар нь найруулгын алдаа болдог.




# НАЙРУУЛГЫН АЛДАА ТҮҮНИЙГ АНГИЛАХ НЬ

Аливаа зүйлийг найруулан бичихэд, найруулгын алдаа хэрхэн үүсэж болдгийг мэдэж байх нь чухал ач холбогдолтой.

*“Найруулгын алдаа гэдэг бол тухайн эх бичвэрийг уншигч хүлээн авч ойлгоход ямар нэг хэмжээгээр хүндрэл учруулж, эргэлзээ гайхал төрүүлж, унших явцыг алдагдуулж, уншигчийн анхаарлыг сарниулж, огт өөр юманд хандуулж буй нэг эсвэл хэд, хэдэн үгийг хэлнэ”*

/ Сэтгүүл зүйн доктор Ч.Чойсамба /

Ер нь найруулгын алдааг хүмүүс ихэвчлэн санамсаргүйгээр, эсвэл монгол хэлний хэм хэмжээ, дүрэм журмыг хайхраагүйгээс хийдэг. Найруулгын алдааны тухай ойлголт өргөн боловч алдааны шинжээс шалтгаалан дотор нь ангилж үзэж болно.



## 1. Үг буруу сонгосон алдаа

Бичиж буй сэдэвт таарах оновчтой үгийг сонгоно гэдэг найруулгын чухал чадвар юм. Аливаа найруулж бичсэн зүйл нь ерөнхийдөө сайн болсон хэдий ч харин ганц л үгийг буруу сонгоход бүх хөдөлмөр талаар болдог тул үгийг зөв сонгон найруулах нь хамгаас чухал болно.

*Тухайн өгүүлж байгаа зүйлийн утга агуулгад тохирохгүй үгийг сонгон хэрэглэснээс үүссэн алдааг үг буруу сонгосон алдаа гэнэ.*

Үг буруу сонгох алдаа нь үгээ онож сонгоогүйгээс хэлэх, өгүүлэх гэсэн зүйлээ бүрэн гүйцэд, утга төгөлдөр илэрхийлж чадахгүй, тэр ч байтугай огт өөр ойлголт төрүүлж болох найруулгын алдаа юм.

Энэ алдаа нь үгийн баялаг муугаас, хэт чамирхсанаас, найруулгын өнгө аяс, найруулгын дээд, дунд, доод гурван зэргийг мэдэхгүйгээс болж үүснэ. Үг буруу сонгосон алдааг дараах гурван төрөлд хуваан тайлбарлаж болох юм.

### **Үгийн баялаг муугаас шалтгаалж үг буруу сонгох**

Аливаа хүн үгийн баялаг хэдий чинээ сайн байна найруулан бичиж байгаа зүйл нь ч төдий чинээ өргөн дэлгэр, баялаг сайхан агуулгатай болж чаддаг билээ. Тийм учраас үгийн баялаг сайтай байх нь сайн найруулгын нэгэн үндэс болдог.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Би өнөөдрийн хийж байгаа ажилдаа нэг апдэйт хийхгүй бол болохгүй нь ээ.” гэсэн өгүүлбэрт “апдэйт” (update буюу өөрчлөлт) хэмээх гадаад үгийг хэрэглэсэн нь тухайн хүний монгол хэлний үгийн баялаг муу байгааг илтгэн харуулж байна.

**Зүй нь:** \_\_\_\_\_

“Би өнөөдрийн хийж байгаа ажилдаа шинэчлэл хийхгүй бол болохгүй нь ээ” гэсэн бол илүү оновчтой болох юм.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Замд цонхоо нээхэд ногооны үнэр сэнхийж, тал нутаг өвсөөр хучигдан ногоорсныг харахад ядаргаа тайлагдах шиг болж бие суларна” (Өдрийн сонин, 2016.07.19. дугаар 5428) гэсэн өгүүлбэрт уг сэтгүүлч “суларна” гэсэн үгийг оновчгүй сонгожээ.

**Зүй нь:** \_\_\_\_\_

“Замд цонхоо нээхэд ногооны үнэр сэнхийж, тал нутаг өвсөөр хучигдан ногоорсныг харахад ядаргаа тайлагдах шиг бол бие сэргэнэ” гэвэл үгийн сонголт оновчтой болно.

### **Хэт чамирхсанаас шалтгаалж үг буруу сонгох**

Найруулан бичихдээ хэт чамирхах нь эх хэлээ мохоох нэгэн шалтгаан болж байна. Ийнхүү хэт чамирхсанаас үг буруу сонгох алдаа гаргах нь түгээмэл.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Сүүлийн үед Монгол улс гадаад харилцаанд нэлээдгүй амжилт гаргалаа” гэсэн өгүүлбэрт буй “нэлээдгүй” хэмээх үгийг хэт чамирхан хэрэглэснээр найруулгын алдаа гаргах нь элбэг болжээ. Учир нь уг үгийн үндэс болох “нэлээд” хэмээх үг нь “үйл хэргийн хэмжээ, үйл байдал бага бус, санаснаас арай илүү” гэсэн утгатай

үг бөгөөд үгүйсгэх “-гүй” (хоолгүй, хувцасгүй г.м.) бүтээврийг залгаснаар тухайн үгийн утгыг үгүйсгэдэг бөгөөд “нэлээдгүй” гэвэл бага гэсэн утгатай болно. Гэвч дээрх жишээнд “бага амжилт гаргалаа” гээгүй харин “нэлээд их амжилт гаргалаа” гэсэн утгаар бичсэн нь ойлгомжтой.

**Зүй нь:** \_\_\_\_\_

“Сүүлийн үед Монгол улс гадаад харилцаанд нэлээд амжилт гаргалаа” гэсэн бол зөв болно.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Зарим дэлгүүр хямдрал гэж хүн төрөлхтнийг хуурдаг” гэсэн өгүүлбэрийн “хүн төрөлхтөн” гэдэг үг өргөн утгатай бөгөөд хүн болж төрсөн бүгдийг хэлдэг.

**Зүй нь:** \_\_\_\_\_

“Зарим дэлгүүр хямдрал гэж хүнийг (үйлчлүүлэгчийг) хуурдаг” гэхэд л болно.

### **Үгийн утгын нарийн ялгааг ойлгоогүйгээс шалтгаалж үг буруу сонгох**

Үг нь цор ганц утгатай байх нь ховор бөгөөд салбар олон утгатай байдаг билээ. Жишээлбэл цагаан гэдэг үгийг сонсоход л цайвар өнгө сэтгэлд бууж байгаа нь энэ үгийн гол утга тэр бөгөөд үүнээс гадна олон утгаар хэлэнд хэрэглэгддэг билээ. Найруулан бичиж байхад утгын хувьд ойролцоо санагдах хэдий ч яг оносон үгийг нь олж бичээгүйгээс үг буруу сонгосон найруулгын алдаа үүсдэг.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Мөнгөн эрдэнэ өргөмжлөл, титэм хүртсэн Шүрэнчимэг аавдаа гэнэтийн бэлэг барихаар болов. Тэрбээр дэд мисс болно гэж яаж санах вэ дээ хэмээн халаглан сууна” гэсэн өгүүлбэрт тухайн бичигч “халаглан суух” гэдэг үгийн утгын нарийн ялгааг мэдэхгүйн улмаас үг буруу сонгосон алдааг гаргажээ.

**Зүй нь:** \_\_\_\_\_

“Мөнгөн эрдэнэ өргөмжлөл, титэм хүртсэн Шүрэнчимэг аавдаа гэнэтийн бэлэг барихаар болов. Тэрбээр дэд мисс болно гэж яаж санах вэ дээ хэмээн баярлан сууна” гэсэн бол зөв найруулгатай болох байжээ.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Дэлхий нийт мэдээллээр хахаж цацаж байхад энэ суманд гэрэл цахилгаан, утсан холбоо ч байхгүй байна” гэсэн өгүүлбэрт “хахаж

цацах” гэдэг үгийн утгыг сайн ойлгоогүйгээс үг буруу сонгосон алдааг гаргажээ.

Зүй нь: \_\_\_\_\_

“мэдээллээр хахаж цацах” бус “мэдээллээр хахаж” гэхэд л болно.

## 2. Үг илүүдсэн алдаа

*Тухайн найруулгад онц шаардлагагүй үгсийг хэрэглэснээс найруулга сунжруу, нуруу, ойлгомжгүй болохыг үг илүүдсэн алдаа гэнэ.*

Аливаа зүйл илүү ч үгүй, дутуу ч үгүй яг тохирсон нь хамгийн оновчтой байдаг. Найруулгад ч бас шаардлагагүй үг нурусанаас хэлэх гэсэн санаагаа ойлгуулахад бэрхшээлтэй болох нь бий. Ийм алдаа нь ихэвчлэн хэлний хэмнэлтийн зарчмыг зөрчсөнөөс үүсдэг билээ. Хэлний хэмнэлтийн зарчим гэдэг нь бичиг, ярианы явцад тухайн найруулгад хэрэггүй үгсийг хасахыг хэлнэ. Тиймээс монгол хэлний үг товчлох ёс, үг хэмнэлтийн зарчмыг мэдэж байх нь чухал байдаг. Үг илүүдсэн алдааг илүү нарийвчлан тайлбарлаж үзье.

**Ойлгомжтой зүйлийг шаардлагагүй үед нурушин тайлбарласнаас үг илүүддэг.**

Жишээ нь: \_\_\_\_\_

“Нэг жилийн хугацаанд Япон улсад хэлний мэдлэгээ дээшлүүлэн сайжруулах хүмүүсийг бүртгэж байна” гэсэн өгүүлбэрт “хугацаанд, улсад, дээшлүүлэх” гэсэн гурван үгийг онц шаардлагагүй үед нурушин үг илүүдүүлжээ. (Нийгмийн толь сонин, 2007.01.9)

Зүй нь: \_\_\_\_\_

“Нэг жилд Японд хэлний мэдлэгээ дээшлүүлэх хүмүүсийг бүртгэж байна” гэхэд хангалттай ойлгомжтой болж чадах юм.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Уг шүүх хуралд түүний эхнэр Цэцэгмаа дуудагдсан бөгөөд түүнийг 20 гаруй хүний мөнгө завшиж, зочид буудал авсан, хөдөлмөрийн хууль зөрчсөн хэргээр шүүхэд дуудаад байгаа аж.”

Зүй нь: \_\_\_\_\_

“Уг шүүх хуралд түүний эхнэр Цэцэгмааг дуудсан бөгөөд 20 гаруй хүний мөнгө завшиж, зочид буудал авсан, хөдөлмөрийн хууль зөрчсөн хэрэгт холбож байгаа аж.”

## Нэр үгийн өмнө шаардлагагүй илүүц тодотгол хэрэглэснээс үг илүүдэх алдаа гардаг.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Өвлийг санагдуулам хүйтэн зайрмагаа аваарай” гэсэн өгүүлбэрт “зайрмаг” гэсэн үгийн өмнөх “хүйтэн” гэсэн тодотгол нь илүүц, шаардлагагүй юм. “Өвлийг санагдуулам” гэдэг нь өөрөө хүйтэн гэсэн утгыг хангалттай илэрхийлж байгаа билээ.

Зүй нь: \_\_\_\_\_

“Өвлийг санагдуулам зайрмагаа аваарай” гэвэл хангалттай төгс найруулга болж чадна.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Аль ч орны бүхий л эмэгтэй хүн бүрийн арьсны онцлог ижил.”  
(Өнөөдөр сонин, 2007.06.16 өдөр)

Зүй нь: \_\_\_\_\_

“Аль ч орны эмэгтэй хүн бүрийн арьсны онцлог ижил.”

## Үйл үгийн өмнө шаардлагагүй илүүц тодотгол хэрэглэснээс үг илүүддэг.

Жишээ нь: \_\_\_\_\_

Английн улс төрч Уинстон Черчиллийн хэлсэн “Never, never, never give up” гэсэн үгийг монголоор “Хэзээ ч, хэзээ ч, хэзээ ч бүү бууж өг” хэмээн үгчлэн орчуулсан нь “бүү бууж өг” хэмээх үйл үгийн өмнө “хэзээ ч” гэдэг үгийг олон давтан шаардлагагүй илүүц тодотгол хэрэглэсэн алдааны жишээ болно.

Зүй нь: \_\_\_\_\_

“Хэзээ ч бүү бууж өг” гэвэл илүүтэй монгол сэтгэлгээнд таарах юм.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Хууль бусаар хулгайлсан юмаа аваачих” гэсэн өгүүлбэрт “хууль бусаар” гэх шаардлагагүй бөгөөд хулгайлах нь өөрөө хууль бус үйлдэл учир тодотгол хэрэггүй.

Зүй нь: \_\_\_\_\_

“Хулгайлсан юмаа аваачих” гэхэд л болох юм.



## Шаардлагагүй үед ойролцоо утгатай үгсийг давтсан тохиолдолд үг илүүдсэн алдаа үүсдэг.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Маш их завгүй байлаа” гэсэн өгүүлбэрт ойролцоо утгатай “маш”, “их” гэсэн үгсийг давтан хэрэглэх нь илүүц бөгөөд ердөө л хүч нэмэгдүүлэхэд болно.

Зүй нь: \_\_\_\_\_

“Маш завгүй байлаа” гэхэд л хангалттай юм.

Хэт чамирхах, дэлгэрэнгүй тайлбарлах гээд өгүүлэх гэсэн зүйлээ дэндүү нуруу болгох зэргээс болж эдгээр алдаа үүсэх шалтгаан бий болдог байна. Сүүлийн үед маш түгээмэл ажиглагдах болсон, ялангуяа ярианд илүүтэй хэт чамирхах маягтай яриа нь үг илүүдсэн алдааг үүсгэж байна.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Санал хэлье гэж бодож байна”, “Баяр хүргэе гэж бодож байна” гэх мэт нь бас л үг илүүдсэн алдаа болно.

Зүй н \_\_\_\_\_

Үүнийг шууд л “Санал хэлье”, “Баяр хүргэе” гэх нь зөв юм.

### 3. Үг дутсан алдаа

*Тухайн сэдэвт зайлшгүй байх ёстой үг, тодотголыг хэрэглээгүйгээс өгүүлж байгаа зүйл тодорхой бус, ойлгомжгүй болохыг үг дутсан алдаа гэнэ.*

Хэлэх гэсэн санааг товч тодорхой, оновчтойгоор илэрхийлэх нь найруулгын чухал шаардлагын нэг мөн боловч харин зайлшгүй байх ёстой үг, тодотголыг хэрэглээгүйгээс өгүүлж байгаа зүйл нь ойлгомжгүй болж үг дутсан алдаа үүсдэг.

Үг дутах алдаа нь учир шалтгааны зайлшгүй шаардлагатай байх үгийг орхисноос утга ойлгомжгүй болох, илэрхийлэх гэсэн санаагаа гаргаж чадахгүй байх явдлаас бий болдог. Өөрөөр хэлбэл ийм алдаа нь бичиж буй зүйлээ хэт товчлох гэж байгаад утгыг гажуудуулснаас, хэлний хэмнэлтийн зарчмыг буруу хэрэглэснээс үүсдэг байна.

Үг дутсанаас найруулгын алдаа үүсэх нь амархан боловч засахад мөн амархан байдаг онцлогтой. Тухайлбал, хаяж гээгдсэн утга ялгах үүрэг бүхий үгсийг олж зөв байрлуулахад л тухайн алдааг засна.

**Жишээ нь:** \_\_\_\_\_  
“Чадвартай бурхан шиг эмч” гэсэн өгүүлбэрт “чадвартай бурхан” биш “авьяас чадвартай эмч” гэсэн утгыг илэрхийлэхэд үг дутсан байна.

**Зүй нь:** \_\_\_\_\_  
“Авьяас чадвартай бурхан шиг эмч” гэсэн нь илүү оновчтой “авьяас” гэх үгийг нэмснээр ойлгомжтой, төгс найруулгатай болгож байна.

**Жишээ нь:** \_\_\_\_\_  
“Хотын өрх бүрийн нэг хүнийг тогтмол ажилтай, орлоготой болгоно” гэсэн өгүүлбэрийг уншихад өрхийн бусад гишүүд нь ажилгүй болж зөвхөн нэг хүн л ажилтай болтлоо ажил хийдэг өрхийн гишүүдийн тоо буурах юм байна гэсэн утгаар ойлгогдож болохоор болжээ. Учир нь нэг өрх мэдээж нэгээс олон гишүүтэй байж болно.

**Зүй нь:** \_\_\_\_\_  
“Хотын өрх бүрийн ядаж нэг хүнийг ажилтай, орлоготой болгоно” гэж найруулбал илүү дээр юм.

**Жишээ нь:** \_\_\_\_\_  
“Ерөнхий сайдыг уяагаар зочлоход чин сэтгэлээсээ бэлгэшээсэн” хэмээх өгүүлбэрт “хурдан морины уяагаар” хэмээн тодотгож ойлгомжтой хэлээгүйгээс үг дутсан алдааг бий болгожээ.

**Зүй нь:** \_\_\_\_\_  
“Ерөнхий сайдыг хурдан морины уяагаар зочлоход чин сэтгэлээсээ бэлгэшээсэн.”

**Жишээ нь:** \_\_\_\_\_  
“Чингисийн замыг хурдлуулахад төр анхаарал тавина” гэсэн өгүүлбэрт мөн л үг дутсан найруулгын алдаа гаргажээ. Албан ёсны харилцаанд “Чингисийн зам” бус “Чингисийн гудамжны зам” гэх нь зөв.

**Зүй нь:** \_\_\_\_\_  
“Чингисийн гудамжны замын ажлыг эрчимжүүлэхэд төр анхаарна” хэмээвэл илүү төгс найруулгатай болж чадах юм.

#### 4. Дүрслэх буюу яруу хэрэглүүрийг оновчгүй сонгосон алдаа

*Тухайн хам сэдэвт сонгосон зүйрлэл, зүйрлэгдэхүүн хоёрын хооронд зөрчил гаргахыг яруу хэрэглүүр оновчгүй сонгосон алдаа гэнэ.*

Яруу хэрэглүүр оновчгүй сонгосон алдаа гол төлөв уран зохиолын хэл найруулгад тохиолддог. Уран зохиолын хэл найруулгын гол онцлог бол зүйрлэлийг ашиглах бөгөөд ингэхдээ оновчгүй сонгосон алдааг гаргадаг байна. Яруу хэрэглүүрийг мөн энгийн найруулгад ашиглах тохиолдолд үгийг оновчгүй сонгосноос алдаа гардаг. Гэхдээ уран зохиолын найруулга харьцангуй чөлөөтэй байдаг бөгөөд зориудаар үг буруу сонгох, үгийн өнгө аяс гажих алдаа гаргадгийг яруу хэрэглүүр буруу сонгосон алдаа гэж үзэж болохгүй юм.

Жишээ нь:

“Тэмээ” гэдэг шүлэгт:

Нээрээ тиймээ гэх шиг

Нэр нь хүртэл тэмээ гэсэн байх бөгөөд “тэмээ” гэсэн үгийг “тиймээ” гэдэгтэй зүйрлэсэн нь уг хоёр зүйрлэл, зүйрлэгдэхүүн хоёр хоорондоо зүйрлэлийн ямар ч холбоогүй байгаа нь яруу хэрэглүүрийг оновчгүй сонгосон алдаа болжээ гэж үзэхээр байна.

Жишээ нь:

“Улиас” гэх шүлэгт:

Хөх өвгөний нүүр шиг

Хүйтэн сарыг хөнжил юугаан болгон гэхэд, алсаас харагдахдаа хэзээ ч хөх өнгөөр харагддаггүй харин шарлаж, эсвэл цагаарч харагддаг сарыг “хөх өвгөний нүүр”-тэй зүйрлэсэн нь оновчгүй болжээ.

#### 5. Үг давтсан алдаа

*Хэлний ямар нэгэн үүрэг зорилгогүй нэг төрлийн үгийг, аль эсвэл ойролцоо ижил утга бүхий үгийг давтахыг үг давтах алдаа гэнэ.*

Аливаа найруулгад нэг үгийг хэт олон давтах нь найруулгыг дордуулдаг. Үг давтах алдаа нь үнэндээ үг илүүдсэн алдааны нэгэн хэлбэр гэж хэлж болно. Товчхон хэлбэл, үгийг хэт олон давтах нь аман ба бичгийн хэлний найруулгад сайн нөлөө үзүүлдэггүй. Үг давтсан алдааг дараах байдлаар ангилан үзэж болно.

## Нэг төрлийн үгийг давтсан алдаа

Жишээ нь: \_\_\_\_\_

“Улсын их хурлыг дөрвөн жилийн хугацаатай сонгодог. Улсын их хурал далан зургаан гишүүнтэй. Улсын их хурлын гишүүд туслахтай байдаг” гэсэн өгүүлбэрт “Улсын их хурал” гэсэн нэг үгийг шаардлагагүй олон давтсан байна.

Зүй нь: \_\_\_\_\_

“Улсын их хурлыг дөрвөн жилийн хугацаатай сонгодог бөгөөд далан зургаан гишүүнтэй, тэдгээр нь туслахтай байдаг” гэвэл илүү оновчтой найруулга болно.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Бид иймийн улмаас энэ ЭХО аппарат хэрэглэдэг эмч нараас бүрдсэн клуб байгуулж хооронд нь туршлага солилцуулах, чадваржуулах зорилготой клуб байгуулах өргөдлөө гаргалаа” гэсэн өгүүлбэрт “клуб байгуулж” хэмээн шаардлагагүй газарт давтан бичсэн нь үг илүүдсэн алдаа болжээ.

Зүй нь: \_\_\_\_\_

“Бид иймийн улмаас энэ ЭХО аппарат хэрэглэдэг эмч нараас бүрдсэн, хооронд нь туршлага солилцуулах, чадваржуулах зорилготой клуб байгуулах өргөдлөө гаргалаа” гэвэл зохистой.

## Ижил, ойролцоо утгатай үгийг давтсан алдаа

Жишээ нь: \_\_\_\_\_

“Их сургуульд орох нь амьдралын маань зорилго минь байсан” гэсэн өгүүлбэрт ойролцоо утгатай “нь, маань, минь” гэсэн хамаатуулах нөхцөлийг давтсанаас үг давтсан алдаа үүсжээ.

Зүй нь: \_\_\_\_\_

“Их сургуульд орох бол амьдралын зорилго минь байсан” гэвэл илүү төгс найруулгатай болно.

Гэхдээ нэг үгийг олон давтаж хэрэглэхийг зөвшөөрдөг найруулгын төрөл бас бийг мартаж болохгүй. Тухайлбал, албан бичгийн найруулгад нэг үгийг олон давтаж, ойр ойр хэрэглэхийг зөвшөөрдөг бөгөөд албан бичгийн найруулга нь товч тодорхой, оновчтой байхыг эрхэмлэдэг билээ.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Монгол Улсын Үндсэн хууль”-д:

Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Хорин нэгдүгээр зүйл.

1. Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

2. Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий

иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа

нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

3. Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн,

сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

4. Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно.

Дээрх Монгол улсын Үндсэн хуулийн энэ хэсэгт байнга давтагдах “Улсын Их Хурал” гэсэн үгсийг уг эх нь албан бичгийн найруулгын төрөл зүйлд хамаарах тул үг давтсан алдаанд оруулан тооцдоггүй.

## 6. Үгийн өнгө аяс гажсан алдаа

*Ойролцоо утгатай олон үгсээс тухайн бичиж буй зүйлдээ оновчгүйг нь сонгон найруулснаас үүдэн гарах алдааг үгийн өнгө аяс гажсан алдаа гэнэ.*

Аливаа найруулгад үгийн өнгө аясыг зөв тохируулах нь найруулгын нэгэн чухал шаардлага болно. Олон утгаар хэрэглэгддэг үгсээс хамгийн зөв оновчтой, тухайн найруулгад тохирох үгийг сонгох нь чухал юм.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Наадмын талбайд хүмүүс хөл тавих зайгүй багширчээ” гэсэн өгүүлбэрт “багшрах” гэсэн үгийг хүн дээр хэрэглэснээс үгийн өнгө аяс гажсан найруулгын алдаа болжээ.

Зүй нь: \_\_\_\_\_

“Наадмын талбайд хүмүүс хөл тавих зайгүй цугларчээ” гэсэн бол оновчтой найруулга болох байлаа.



# НАЙРУУЛГЫН БУС АЛДААНЫ ТӨРӨЛ, ХЭЛБЭР



## 1. Баримтын алдаа.

*Тухайн юм үзэгдэл, баримт сэлтийн талаар мэдэхгүй, эсвэл тойм төдий төсөөлөлтэй байснаас үүссэн алдааг баримтын алдаа гэнэ.*

Баримтын алдаа тухайн асуудлыг нарийн нягтлаагүйгээс, хариуцлагагүй хандсанаас, нэрэлхүү зангаас, гүйцэд лавлаагүй зэргээс болж үүсдэг. Мөн цэг таслал, үг үсэг, тоо баримт зэрэг бүх зүйл энэ алдаанд хамаарна. Сэтгүүлчдийн хувьд баримтын алдаа нь хэл найруулгын төдийгүй, мэргэжлийн болон ёс зүйн алдаа болдог учир баримтыг, нэн ялангуяа он, сар, өдөр, нэр, овог, албан тушаал зэргийг байнга нягтлан шалгаж хэвших нь чухал.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

...Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр энэ сарын 27-28 ны өдрүүдэд Хэнтий аймгийн төв Өндөрхаан хотод ажиллалаа. (Өглөөний сонин, 2008.12.01 №231/554)

**Зүй нь:** \_\_\_\_\_

Сэтгүүлч өнгөрсөн сарын үйл явдлыг энэ сарын гэж бичснээрээ баримтын алдаа гаргасан байна.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Нийт есөн алт нэг мөнгө, хоёр хүрэл, нийт 12 медаль зүүж, багийн дүнгээр тэргүүн байр эзэлсэн. (Өдрийн сонин, 2007.01.12 өдөр )

**Зүй нь:** \_\_\_\_\_

Энэ өгүүлбэрт таслал орхиж баримтын алдаа үүсгэсэн байна.

## 2. Логик буюу учир зүйн алдаа.

*Сэтгэхүйн хууль, учир шалтгааны хэм хэмжээг зөрчсөнөөс үүссэн алдааг логикийн алдаа буюу учир зүйн алдаа гэдэг.*

Учир шалтгааны хэм хэмжээг зөрчих гэдэг бол сэтгэлгээний гол хууль болох адилтгал, эсрэгцэл, ангилах, хангалттай үндэслэгээний хуулийг зөрчсөнөөс үүсдэг. Уг алдаа нь уншигчдад эргэлзээ төрүүлж, унших явцыг сарниулдаг сөрөг талтай. Иймд логикийн буюу учир зүйн хуулиудыг сайн мэдэж байх нь чухал. Өөрөөр хэлбэл өгүүлэгч этгээд өгүүлж бичиж байгаа зүйлийнхээ холбоо дэс дарааг алдсанаас үүснэ.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Хаалттай үзүүлэх тоглолт болно. Өргөнөөр ирж үзнэ үү. (Телевизийн зарлал) “Хаалтай” гэж өргөнөөр оролцох боломжгүй зүйлийг хэлдэг.

**Зүй нь:** \_\_\_\_\_

Бүх нийтэд нээлттэй үзүүлэх тоглолт болно. Өргөнөөр ирж үзнэ үү.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Манай багийн хамт олон АНУ руу явган аялал хийхээр бэлтгэж байна. АНУ руу явган аялал хийх боломжгүй учраас учир зүйн алдаа гарсан.

**Зүй нь:** \_\_\_\_\_

Манай багийн хамт олон АНУ руу аялал хийхээр бэлтгэж байна.

## 3. Хэл зүйн алдаа.

*Монгол хэлний үг бүтэх ёс, үгийн хэлбэржилт, хэл зүйн дүрмийн хэм хэмжээг зөрчсөний улмаас үүссэн алдааг хэл зүйн алдаа гэдэг.*

Үүнд үгийн хэлний зүйн утгыг оновчгүй хэрэглэсэн, үйлийн цаг, хэв, байдлын утгыг буруу гаргасан, үгсийн аймгийн найруулгын үүргийг оновчгүй илтгэсэн зэрэг алдаа орно.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Сэтгүүлч нар сонирхолтой асуулт асуусан нь хурлын уур амьсгалыг идэвхжүүлэв.

**Зүй нь:** \_\_\_\_\_

Сэтгүүлчид сонирхолтой асуулт асуусан нь хурлын уур амьсгалыг идэвхжүүлэв.



Жишээ нь: \_\_\_\_\_

Олон сонинуудыг зориуд судалж цаг гарздах тэнэг бодол надад төрсөнгүй.

Зүй нь: \_\_\_\_\_

Олон гэсэн үг нь олон тоог илэрхийлж байхад сонинуудыг гэж олон тоог давхардуулан хэрэглэсэн алдаа болжээ. Олон сониныг зориуд судалж цаг гарздах тэнэг бодол надад төрсөнгүй.

Жишээ нь: \_\_\_\_\_

Мөн зарим байгууллагууд, хэд хэдэн **Зарим байгууллагууд өндөржүүлсэн бэлэн** төлөөлөгчид, олон хүмүүс гэх мэтээр 2016 оны 6 сарын 29 олон тооны нөхцөлийг олон тоог заадаг үгтэй давхардуулан хэрэглэсэн нь илэрхий жишээ элбэг байдаг.



Өнөөдөр Улаант Онцгой байдлын газар өндөржүүлсэн бэлэн санал өгөх хэсгийн

Зүй нь: \_\_\_\_\_

Олон цөөн нь тусгай үгээр буюу тодорхой тоогоор илэрсэн үед уг нэр үгэнд олон тооны нөхцөлийг залгадаггүй гэсэн дүрмийг зөрчсөнөөс дээрх алдаа үүсдэг. Зарим байгууллага, хэд хэдэн төлөөлөгч, олон хүн гэх мэт.

#### 4. Гоо зүйн алдаа.

*Хүмүүсийн гоо зүйн боловсрол, ёс зүйн хэм хэмжээ зэрэгт аливаа нийтэлж байгаа зүйл үр дүнтэй өгөөжтэй байх шаардлагыг зөрчсөн алдааг хэлдэг.*

Жишээ нь: \_\_\_\_\_

Эдгээр сайхан бүсгүйчүүдийг анх харахад намрын хагдарч буй алаг цэцэгс мэт санагдсаныг нуух юун.

Зүй нь: \_\_\_\_\_

Намрын хагдарч байгаа цэцэг сайхан харагддаггүй гунигтай харагддаг. Эдгээр сайхан бүсгүйчүүдийг анх харахад дэлгэрч буй алаг цэцэгс мэт санагдсаныг нуух юун.

Жишээ нь: \_\_\_\_\_

Дээр нь муу дээр муухай, муухай дээр улцан гэгчээр ажил үүргээ гүйцэтгэхээр явсан олон хүний амь эрсэдсэн золгүй явдал болж... (Өнөөдөр сонин, 2007.06.21, Үнийн өсөлтийн эсрэг жагсаа

Зүй нь: \_\_\_\_\_


Энэ өгүүлбэрт оновчгүй зүйрлэл хэрэглэсэн. Энэ өгүүлбэрт чухам ямар утга гаргах гэж байгаа нь ойлгомжгүй байна.

Ийнхүү аливаа зүйлийг найруулан бичихэд, найруулан бичих арга ухаан машид хэрэгтэй байдгаас гадна, найруулгын алдаа хэрхэн үүсч болдгийг мэдэж байх нь чухал ач холбогдолтой.



# ҮГ БҮТЭХҮЙН НАЙРУУЛГЫН ОНЦЛОГ

Үг бүтэх ёс, хэлний дотоод зүй тогтлыг танин мэдэхгүйгээр үг бүтэхүйн найруулгыг баримтлах бараг боломжгүй юм. Тиймээс үг бүтэхүйн найруулга бол найруулгын төрөл дотроос хамгийн адармаатай нь болно. Үг бүтэхүйн найруулгыг нэр үг, үйл үг, тэмдэг нэр бүтэхүйн найруулга гэж ангилан үзэж болно.



Доор үг бүтэхүйн найруулгад гардаг түгээмэл алдаа, түүнийг хэрхэн засаж болох талаар өгүүлсэн болно.

## 1. Нэр үг бүтэхүйн найруулга

*Юм, үзэгдлийг ерийн болон оноон нэрлэсэн үгийг нэр үг гэнэ. Тухайлбал ширээ, сандал, зураг, Бат, Дорж, Орхон гэх мэт.*

Нэр ба үйл үгийн идэвхтэй язгуур, үндсэнд дагавар залгах, үг үндэс хоорондоо хоршин нийлэх аргаар монгол хэлний нэр үг бүтнэ. Нэр үг бүтээх дагаврыг зөв хэрэглэх, түүний утгыг гүн ухаарах, илтгэх өнгө аясыг нямбай тунгаах нь найруулгад чухал үүрэгтэй.

### а) Нэр язгуур, үндсээс үг бүтээх дагаврын найруулга

Техник технологи, харилцаа холбоо асар хурдтай хөгжиж буй өнөө үед хүмүүс урд өмнө байгаагүй олон зүйлийг зохион бүтээсээр байна. Тэр бүгдийг шинээр нэрлэх, мөн гаднын аль нэг хэлээр байгаа нэрийг орчуулах, өөрийн хэлээр оноох хэрэгцээ шаардлага ч урьд өмнөх үеэс нэмэгдэж байна.

Аливаа нэг зүйлийг нэрлэх, нэр томъёог онооход нэр үг бүтээх дагаврын үүрэг нөлөө их. Гэвч нэр томъёоны зүйлд нэр үг бүтээх дагавруудыг буруу зөрүү хэрэглэсэн зүйл нэлээд тохиолддог. Найруулгад

түгээмэл тохиолддог зарим нэр үг бүтэхүйн үүдсэн буруу үүссэн үсийг, засах хувилбарыг санал болгоё.

**Авлигал бус авлига.** Шунан ховдоглох сэтгэлийн эрхээр бусдаас ёс бусаар авсан эд зүйлийг заан нэрлэсэн “авлигал” гэдэг үгийг одоо ч өргөнөөр хэрэглэж байна. Гэтэл ийм нэр үг монгол хэлний үгийн санд байхгүй, бүтцийн хувьд буруу бөгөөд зөв хэлбэр нь “авлига” юм. Монгол хэлэнд нэр үгээс үйл үүсгэх -л дагавар байхаас бус нэрээс нэр үүсгэдэг -л дагавар байдаггүй. Уг нэр үндсээс авлигад шунан дурлагч этгээдийг заасан авлигач, авлига авах үйлийг заасан авлигал- зэрэг үндэс үүссэн байна. Мөн ижил бүтэцтэй авлага гэсэн нэр үг буй. Авилга, авлага нь хоёулаа ав- гэсэн үйл язгуурт нэр бүтээх дагавар залгаж бүтсэн нэрлэлт. Утгын хувьд бусдаас авах ёсгүй зүйл буюу утгаа хээл хахууль авахыг заасан нэрлэлт нь авлига, авах ёстой эд зүйлийг заасан нь авлага болно.

**Хэрэгслэл бус хэрэгсэл.** Мөн хэрэгслэл (бичгийн), эрмэлзлэл (хүсэл) зэргээр бичсэн зүйл нь хааяа хэвлэл мэдээлэлийн хэрэгсэл болон хаяг шошигт таарах нь мөн л “авилгал”-тай ижил буруу үүссэн үг. “Хэрэгслэл” бус “хэрэгсэл” гэх нь зөв болно. “Хэрэгсэл” гэдэг үг нь хүмүүсийн өдөр тутмын амьдрал, үйлдвэрлэлд зарцуулагдах юмсыг заан нэрлэсэн утгатай үг.

**Эрмэлзлэл бус эрмэлзэл.** Орчин цагийн монгол хэлэнд үйлээс нэр үндэс үүсгэх -л дагавар байдаг. Тухайлбал: бод-бодол, үз-үзэл, сана-санал, хэвлэ-хэвлэл, гар-гарал, бүтээ-бүтээл гэх мэт. Гэтэл шинэ үсгийн дүрмээр эрмэлзлэл гэж бичээд буй үгийг өмнөх жишгээр задлан үзвэл эрмэлзэл-эрмэлзлэл гэж үүсэх ёстой болно. Монгол хэлний түүхэн баримт дурсгалд эрмэлзэл- гэсэн үйл үндэс ер байхгүй. Тэгэхээр “эрмэлзлэл” нь эрмэлзэ- гэсэн үйл үндсэнд нэр үүсгэх -л дагавар залгаж бүтсэн “эрмэлзэл” гэх нэр үгийн ташаа бичлэг болно.

## АВЛИГАЛ, ЯДУУРАЛ, АЙДАС БОЛГООМЖЛОЛ БАЙВАЛ ТЭНД ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ БАЙХГҮЙ

© 2011/05/03 / 0 сэтгэгдэл

Өнөөдөр Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр. Энэ өдрийг тохиолдуулам МСНЭ-ийн ерөнх Т.Балсансүрэнтий манай сурвалжлагч уулзаж ярилцлаа.

“Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг хэдийнээс тэмдэглэж эхэлсэн юм ба, Монголд тэмдэглэж нэв?”

“Одоогоос 20 жилийн өмнө хэд хэдэн орны сэтгүүлчид өөрсдийн дуу хоолойгоо нэгтгээд Нэлсиг Виндхук хотноо цугларч, хэвлэлийн эрх чөлөөний асуудлаар санал бодлоо солилцжээ. Энэ нь, хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэх эх үндсийг тавьсан. Тэд Хүний эрхийн түгээмэл тунх 19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй нлэрхийлэх эрхийг баталгаажуулсан үндсэн зэр хамгаалах зорилгоор Виндхукийн тунхаглалыг баталсан түүхтэй.


## 430 тээврийн хэрэгслэл үйлчилгээнд явж байна

ТЭМЭ Admin  
2015 оны 10 сарын 7



**Дурдатгал бус дуртгал (дурадхал).** Дурдатгал хэмээн бичиж буй нэр үндсийг бүтцээр нь задалбал дурдатга- + -л болно. Гэтэл монгол хэлэнд дурдатга- гэсэн үйл үндэс байхгүй. Энэ нь дурад-(үйл үндэс) +ха (үйлдүүлэх хэвийн бүтээвэр) +л (үйлээс нэр үг бүтээх дагавар) гэж үүссэн бөгөөд дуртгал хэмээн бичих ёстой. Дурдах нэгэн зүйл, дурд-, дурс- гэсэн үйл үндсүүд -д, -с гийгүүлэгчийн сэлгэцээр үүсжээ. Монгол хэлний д, с гийгүүлэгч дадах дасах, багадах багасах, уртдах уртсах, богинодох богиносох зэргээр сэлгэх тохиолдол цөөнгүй. Тэгэхээр дурсгал, дуртгал хоёр нь бүтцийн хувьд яг адил юм.

**Дурсамж, дурдатгал, бүтээмж шингэсэн "Чөлөөт хэвлэл сан"**



**Гарваль бус гарал.** Орчин цагийн монгол хэлний үг бүтэх ёсонд буруу хэвшсэн нэг хэлбэр бол гарвал(ь) юм. Монгол хэлэнд үйлээс нэр үг бүтээх -вал(ь) дагавар байхгүй бөгөөд гар- гэсэн үйл язгуураас гарал, гарам, гарц, гараа, гарлага, гарам зэрэг нэр үндэс үүсдэг. Тэгэхээр уг гарал, угсаа гарал, гарал үндэс гэж хоршин хэрэглэх нь зүйтэй байна.

**Монголчуудын зан суртахууны гарваль**

© 20100302 / / 0 сэтгэлд  
 Бие хүний нэгэн чухал үнэт зүйл нь өөрийнх нь ёс суртахуун суурилсан байдал. Магад монголчууд биднээ дутаагад байгаа нэгэн зүйл үндэ ч оршиж байгаа юм болов уу. Мөнгө хэдэн зуун жилийн өмнөх үндэстэй зан суртахууны үзэсрээрийг гайвчлалтай байсан ө улс орныг байсан юм байна. Харамсалтай нь түүнийг ХХ зууны хэвэр "феодализмыг шорголд" хэмээн бүрэн эршээхэд эрэггүй эрсдэл автагдан үгүй шийтгэжээ" хэмээн II хааны гавь яаг зүтгэлтэн, ага шалт С.Нарангэрэл "Мон - гол чуудын зан суртахууны га номынхоо өмнөтгөлд өгүүлжээ. Монголчуудын зан суртахууны гарваль Чингис хааны за суртахууны үнэт зүйлс байв. Шударга ёс, зориг зүрх, ичиг эмээх сэтгэл, нийгэм нийгүлдс найрсаг, зочлолтыг зан, үнэн, нэр төр, тэсвэр гавчээр, урвалгүй сэтгэл, янж агаа энэрэх / монгол эмэгтэйчүүдийн зан суртахууны талаар Чингис хаан нуу гэж үзэж байсан талаар / бүхэн энэ номноос мэдэж авах болно. Монгол хүний мөс чанар гэнэвч, зан суртахуун дог өнөө үед С.Нарангэрэл эрхийн энэ бүтээлийг уншихан бүрэн нэгдэх бодох биз ээ. Даавриш

Нэр үг бүтээх дагаврын найруулгад холбогдох заалтуур, наалтуур, саалтуур, суултуур, угаалтуур, хөөлтүүр, цоолтуур, шүүлтүүр зэрэг найман үг байна. Эдгээр үгийн бүтэц дэх -уур/-үүр дагаврыг зарим судлаач нэрээс нэр үг бүтээх дагавар гэж тодорхойлдог ч үнэндээ монгол хэлэнд нэрээс нэр үг бүтээх -уур дагавар байдаггүй. Энэ нь чухамдаа багаж хэрэгслийн утга бүхий соруул, шахуур гэх мэтээр үйлээс нэр үг бүтээдэг -уур2/-уул2 дагавар боловч дээрх үгст нэр үг бүтээх –лт дагаврын араас залгаж дагаврын байрлалын тогтолцоог зөрчжээ. Үүнийг заагуур, саагуур, суугуур, угаагуур, хөөлүүр, цоолуур, наалт, шүүр гэвэл хэлний бүтэц, зүй тогтолд нийцнэ.

**б) Үйлээс нэр үг бүтээх дагаврын найруулга**

Харилцаа холбоо өргөжин хөгжиж дэлхийн өнцөг булан бүрд өрнөж буй аливаа үйл явдлыг монголчууд бид цаг тухайд нь хүлээн авч байна.

Монголын хэвлэл мэдээллийн байгууллагууд гол төлөв англи, орос эх сурвалжаас гадаад мэдээгээ орчуулан бэлтгэдэг. Тухайн хэлний өгүүлбэрт орсон бүх нэр үгийг монгол хэлний нэр үгээр орчуулах гэсэн эрмэлзлээс үүдэж, сүүлийн жилүүдэд үйлийн явц байдлыг заасан нэр үг голчлон бүтээх -лт дагаврыг үг бүтээх чадамжаас нь хэтрүүлэн хэрэглэх болжээ.

-лт дагаврыг хэтрүүлэн хэрэглэсэн байдал:

Жишээ нь: \_\_\_\_\_

Огцом зогсолт хийх нь осол гарахад нөлөөлдөг.

Зүй нь: \_\_\_\_\_

Огцом зогсох нь осол гарахад нөлөөлдөг

Жишээ нь: \_\_\_\_\_

Багш нар тохиролцоонд хүрээгүй тохиолдолд маргаашаас ажил хаялт хийнэ.

Зүй нь: \_\_\_\_\_

Тохиролцохгүй бол багш нар маргааш ажил хаяна.

Жишээ нь: \_\_\_\_\_

Японд газар хөдлөлт боллоо.

Зүй нь: \_\_\_\_\_

Японд газар хөдөллөө.

Жишээ нь: \_\_\_\_\_

Хэрэв дүрэм зөрчвөл жолооч нар 10 онооноосоо хасалт хийлгэх юм.

Зүй нь: \_\_\_\_\_

Жолооч нар 10 онооноосоо хасуулна

Жишээ нь: \_\_\_\_\_

Цаашилбал “өвдөлт өгөх, нийлүүлэлт хийх, доргилт авах, тууралт гарах, бүрдүүлэлт хийх, хяналт тавих, хайлт хийх, дамжуулалт гүйцэтгэх” гэх мэт нэн олон жишээг жагсааж болно.

Зүй нь: \_\_\_\_\_

Эдгээрийг “өвдөх, доргих, туурах, нийлүүлэх, бүрдүүлэх, хянах, хайх, газар хөдлөх” гэж найруулбал монгол хүнд ойр тусаж, илүү нэг үг хэмнэнэ.

Жишээ нь: \_\_\_\_\_

Монгол хэлэнд ялалт, амжилт, ололт, дүгнэлт, асуулт, уулзалт, хүсэлт, сургалт, байгуулалт, хариулт гэх зэргээр оновчтой үүссэн нэр үг олон бий. Гэтэл төмсний ургалт, газар бордолт, тариалан усалт, төрөлтийг бүртгэх гэх мэт зүй бус нэр үүсгэх гэм байна.

Зүй нь:

Газар бордох, төмс ургах, тариа услах, гэрлэсэн төрснийг бүртгэх гэж найруулбал эвтэйхэн болно.

**Ажилбар бус Ажиллавар.** Үг бүтээх дагаврын найруулгыг судалсан эрдэмтдийн анхаарлыг татдаг үг бол “ажилбар” юм. –вар4 дагавар үйлээс нэр үг бүтээдэг бол тус үгийн бүтцэд ажил гэсэн нэрийн ард оржээ. Энэ нь монгол хэлний үг зүйн хэм хэмжээг илт зөрчсөн хэрэг билээ.



(анагаах)



Хэл

1. Эд эрхтэнд гараар болон мэсээр хийх эмчилгээний арг

2. Гараар болон мэсээр анагаах өвчин, эмгэг, эмчилгээ аргыг судалдаг анагаахын салбар ухаан.

Жишээ нь:

41 хүүхдэд үнэ төлбөргүй зүрхний мэс ажилбар хийх аж. Нүдний даралтаас болж хараа муудахад мэс ажилбар хийдэггүй.

Зүй нь:

эд-л-бэр, хайч-л-бар, хувь-л-бар, шат-л-бар зэрэгтэй ижил бүтэцтэй (ажил-л-бар) үг. Хэлэх явцад дараалан орсон “л” гийгүүлэгчийн нэг нь сугарч, тэрхүү сугарсан хэлбэрийг бичигт шууд тэмдэглэснээр ажилбар гэдэг буруу хэлбэр хэвшжээ. Зөв хэлбэр нь ажиллавар юм.

**Чадавх бус чадамж.** Үйлээс нэр үг бүтээх дагаврын найруулгад монгол хэлний үг бүтэх ёсыг харгалзалгүй буруу үүсгэсэн цөөн үг байна. Түүний нэг нь орос хэлний потенциал гэдэг үгийн орчуулга болох чадавх хэмээх үг юм. Энэ нь идэвх, усавхи, бүдэвх зэргийг төсөөгөөр үүссэн үг бөгөөд монгол хэлэнд үйлээс нэр үг бүтээх -vx дагавар байхгүй. Тиймээс боломж, бүтэмж, зохимж гэдгийн адил чадамж (чадах нөөц боломж) гэж хэрэглэвэл монгол хэлний дотоод зүй тогтолд нийцнэ.

**Суралцагч(ид) болон суралцагс(ад) утгын ялгаа.** -гч дагавартай холбоотой өөр нэг зүйл нь -гч(ид) болон -гс(ад) гэсэн нийлмэл хэлбэрийг хутгах алдаа түгээмэл гарч байна. Үйлт нэрийн –сан4 нөхцөлийн ард олон тооны -д залгасан “-гсад4” хэмээх “өнгөрсөн цагт хам олны утга” бүхий нийлмэл хэлбэрийг одоо цагийн утгаар ойлгон буруу хэрэглэсэн нь цөөнгүй ажиглагддаг.

Жишээ нь:

Гадаадад суралцагсад төлбөрөөс чөлөөлөгдөхийг хүсжээ. Оюутолгойн ажиллагсад “ухаалаг малгай”-тай боллоо. “Ажиллагсад, суралцагсад” ажиллаж байсан, сурч байсан хүмүүс “ажиллагчид, суралцагчид” одоо ажиллаж, сурч буй хүмүүс юм. Өмнөх жишээнд бичигч одоо сурч, ажиллаж буй хүмүүсийн тухай өгүүлж буй учир

Зүй нь: \_\_\_\_\_

Гадаадад суралцагчид төлбөрөөс чөлөөлөгдөхийг хүсжээ.  
Оюутолгойн ажиллагчид/ажилчид “ухаалаг малгай”-тай боллоо

## 2. Үйл үг бүтэхүйн найруулга

*Юмс үзэгдлийн үйл хөдлөл, явц байдлыг нэрлэн заасан үгсийг үйл үг гэнэ. Жишээ нь: үз-, ир-, нүү-, яв- гэх мэт.*

Үйл үгс нь хэв, байдал, цаг, төлөв, биеийн айтай, өгүүлбэрт ихэвчлэн өгүүлэхүүний үүрэг гүйцэтгэдэг. Үйл үг нь дагаврын аргаар бүтэхдээ нэр язгуур, үндэс, үйл язгуур, үндэс, дүрслэх язгуур, дуу авиа дууриах үг дээр дагавар залгадаг.

### а) Нэр язгуур, үндсээс үйл үг бүтээх дагаврын найруулга.

Нэр язгуур, үндсийн араас үйл үг бүтээх дагавар орж тухайн нэрийг үйл үг болгодог. Ингэхдээ нэрийн үндсэнд залгавал үйл үг бүтээх дагавруудын утгаас хамаарч эд зүйлийг эзэмших, эдэлж хэрэглэх, түүнчлэн юм, үзэгдэл өсөж төлжих, хэвшиж дадах зэрэг утга илтгэдэг аж. Харин тэмдэг нэрийн үндсэнд залгавал үйл үг бүтээх дагавруудын утгаас хамаарч үүсгэгч үндсийн утга дагуу шинж тэмдэгтэй болох, болгох, шинж тэмдэг нь ихсэх, багасах, хэтийдэх, хэвшин тогтох зэрэг утга илтгэдэг болно.

Жишээ нь: \_\_\_\_\_

Сүүлийн үед ажил хэмээх нэр үндсэнд -л/-на4 дагавар залгаж бүтсэн ажилла- гэдэг үйл үгийг хэл зүйн хувиллаар хэлбэржүүлэхдээ ажилдаг, ажилж, ажиллаа гэх мэтээр буруу бичсэн зүйл сонин сэтгүүлд харагдах болсон байна.

Шадар сайд Баянзүрх дүүрэгт ажиллаа

Ч.Хрээвэ © 2017/03/17 (2017-03-17)



Зүй нь: \_\_\_\_\_

ажилладаг, ажиллаж, ажиллалаа гэж бичнэ.



## б) Үйл язгуур, үндсээс үйл үг бүтээх дагаврын найруулга

Орчин цагийн монгол хэлэнд нэрээс үйл үг бүтээх загварыг хуулж үйлээс үйл үг бүтээсэн цөөн тохиолдол байдаг.

Жишээ нь: баларш-, өгөрш- зэрэг үгийн язгуурыг үйл язгуур гэж эндүүрч, нэрээс үйл үг бүтээх -ш дагаврыг дар-, үх- гэсэн үйл язгуурт залгаж дарш-, үхэш- хэмээх үгийг бүтээсэн байна. Түүнтэй нэгэн ижил зүгшир-, тайвшир-, туйлшир- зэргийн төсөөгөөр нэрээс үйл үг бүтээх -шир дагаврыг мөн үх- хэмээх үйл язгуурт залгаж үхшир- гэдэг үг үүсгэжээ.

Өөр нэг сонирхолтой жишээ бол яаравчил- юм. Түүнийг зарим судлаач яар- хэмээх үйл үндсэнд үйлээс үйл үг бүтээх -вчил дагавар залгаж бүтээсэн үг гэж үзсэн байдаг ч үнэндээ бүдүүвчил-, нарийвчил-, түргэвчил-, хөнгөвчил- зэргээс мөн л төсөөгөөр үүссэн үг юм.

Бүдүүн, нарийн, хурдан, түргэн, цөөн зэрэг үндсэнд нэрээс үйл үг бүтээх -чил дагавар залгахад дараалан орсон хэлний урдуурх гийгүүлэгч (н, ч) ондоошдог авианы байрлалын хуулиар “н” гийгүүлэгч уруулын “м” болж, “м” нь хэлэх дуудахад хялбар болж “в”-ээр сэлгэдэг аж.

Энэ мэтээр үг бүтээх дагавар бүрийн найруулгын үүрэг тун нарийн бөгөөд түүнийг хэчнээн оновчтой хэрэглэвээс найруулга төдий чинээ төгөлдөр болно.

## 3. Тэмдэг нэр бүтэхүйн найруулга


*Юмс үзэгдлийн шинж чанар, бэлгэ тэмдэг, өнгө зүс, хэлбэр дүрс, үйл хөдлөлийн болц байдал зэргийг заах үгсийг тэмдэг нэр (үг) гэнэ. Тухайлбал сайн, муу, хатуу, зөөлөн, хар, цагаан, өндөр, нам, хурдан, түргэн гэх мэт.*

Хэлний хөгжил хувьсалтай холбоотойгоор зөвхөн нэр язгуур, үндсэнд залгадаг –лаг 4 дагаврыг сүүлийн жилүүдэд эмэгтэйлэг, эрэгтэйлэг, шинэлэг, хатуулаг гэх мэтээр тэмдэг нэрийн үндсэнд залгаж, үг бүтээх дагаврын байрлалын тогтолцоог зөрчдөг цөөн тохиолдол байна.

Гайхалтай гэхэд ч багадаа :  
**ШИНЭЛЭГ** санаа

Огноо: 2014/12/02


Мөн тэмдэг нэр бүтээх –дуу2 дагаврыг нэрийн үндсэнд залгасан “бөөрөнцөгдүү” хэмээх ганц тохиолдол монгол хэлний тайлбар толь бичгүүдэд тохиолдоно. Гэвч –дуу2 зөвхөн тэмдэг нэрийн үндсэнд залгаж тухайн тэмдгийн бууруу шинжийг заадаг учир бөөрөнцөг (бяцхан бөмбөлөг хэлбэртэй биеийн тамир, спортын шидэж, түлхэх нэгэн зүйл цул хэрэгсэл) хэмээх нэр үндсийн ард хэлний зүй тогтлын хувьд –дуу2 дагавраас –рхуу2 илүү тохирно.



# ҮГ ХУВИЛАХУЙН НАЙРУУЛГА ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Нэг үгийн дараа ямар ч хамаагүй үг байрлаж болохгүйн адил нэг дагавар, нөхцөлийн дараа бусад дагавар, нөхцөлийг хамаагүй залгаж болохгүй. Энэ бол монгол хэлний найруулгын эрхэм дэг ёс юм.

Монгол хэлний үг хувилах ёс нь нэрийн хувилал, үйлийн хувилал гэсэн хоёр том бүлэгт хуваагддаг бөгөөд дотроо нарийн дэс дараалал, онцлогтой байдаг.



## 1. Нэр үг хувилахуйн найруулга

Монгол хэлний нэр үг нь тоо, тийн ялгал, хамаатуулах нөхцөлөөр хувилна.

### а) Олон тооны бүтээврийн найруулга

*Орчин цагийн монгол хэлэнд ерөнхий буюу хэсэг олон тоо заах – ууд2, -нар -д, -с, -чууд2, -уул2 дагавар буй.*

Олон тооны утга илтгэх эдгээр дагавар нь олон тоо заах нийтлэг үүрэгтэй боловч хэрэглээнд олон өнгө аястай болон хөгжиж, нэг хэм хэмжээнд баригдахгүй болсноос үүдэж хэлний хэрэглээнд дараах зөрчил буюу гаж хэрэглээ бий болжээ.

## • Ижил утга үүрэгтэй дагаврыг давхарлан залгасан алдаа

Олон тоог илэрхийлсэн охид, ноёд, бид зэрэг үгийн араас дахин олны утга бүхий –ууд<sup>2</sup>, -нар<sup>4</sup> дагаврыг давхар залгаж охидууд, ноёдууд, бид нар, тэд нар гэх мэтээр хэрэглэх алдаа түгээмэл байдаг. Мөн олон тооны -с дагавар залгасан эмс, хүмүүс зэрэг үндсэнд дахин олны утга илэрхийлэх –ууд<sup>2</sup> (эмсүүд, хүмүүсүүд) дагавар залгах алдаа ажиглагдаж байна. Хэлний хэм хэмжээний үүднээс нэг үгэнд ижил үүрэгтэй дагавар дараалан орох ёсгүй. Аливаа зүйлийг найруулан бичихдээ дээрх зүйлийг анхаарвал зохино.

## • Тооны зохицолтой холбогдох зарим алдаа

Тодорхой болон тодорхойгүй тооны тодотголтой жинхэнэ нэр олон тооны дагавраар хэлбэржихгүй. Үүнийг зөрчсөн алдаа аман ба бичгийн хэлэнд түгээмэл тохиолдож байна.

Жишээ нь: \_\_\_\_\_ Зүй нь: \_\_\_\_\_

арав орчим оюутнууд  
мянга гаруй ажилчид  
олон хүмүүс  
зарим асуудлууд  
хэсэг хүүхдүүд  
газар газрын хүмүүс

арав орчим оюутан  
мянга гаруй ажилчин  
олон хүн  
зарим асуудал  
хэсэг хүүхэд  
газар газрын хүн

## • Дагаврын найруулгын ялгамжийг үл мэдэхээс үүдсэн алдаа

Монголчууд эрт дээр үеэс эхлэн бүхэл бүтэн ард түмэн, үндэстэн угсаатныг нэрлэхдээ -чууд<sup>2</sup>, -ууд<sup>2</sup> гэсэн олон тооны дагавар хэрэглэсээр ирсэн билээ.

Тухайлбал Оросууд, америгууд, энэтхэгүүд, хятадууд гэхчлэн хэлж нэрлэдэг. Харин аль нэгэн улс орны дотоод дахь аймаг, хошуу, хот балгадын оршин суугчид буюу нутаг нугынхныг олон тоонд хамаатуулан нэрлэхдээ хотынхон, манай нутгийнхан, Булганыхан, Сайн ноёныхон гэх мэтээр -хан, -хон, -хэн гэсэн арай бэсрэг тоо хэмжээг илэрхийлсэн хамаатуулах дагаврыг хэрэглэж ирсэн уламжлалтай.

Гэтэл энэ ялгамжийг мэдэхгүйгээс буруу хэрэглэх тохиолдол нэлээд түгээмэл байна.

Жишээ нь \_\_\_\_\_

Улаанбаатарчууд, Баянголчууд, Төв аймагчууд, гэх мэтээр

## • Тооны бүтээврийг дараах тохиолдолд хэрэглэхгүй

- Тоолж болохгүй зүйл: элс, шороо, ус, цас, бороо
- Хос эрхтний нэр: нүд, гар, хөл
- Ертөнцөд ганц байдаг юм: нар, дэлхий
- Хийсвэр ухагдахуун: сэтгэл, хайр, гуниг
- Оноосон нэр, юмын нэр сэлтэд хэрэглэхгүй: Алтайн бүргэд
- Олны утгатай тодотгол бүхий үг: олон хүн, цөөн гэр
- Олны утгатай үйл үгийн холбогдох нэр үг: мал бэлч-, од түг-
- Харилцан үйлдэх хэвийн -лд бүтээвэр бүхий үйл үгийн холбогдох нэр үг: бөх барилд-, морь уралд

Жинхэнэ нэрийн тооны айтай холбогдох хэл зүйн найруулгын хэм хэмжээ, түүнийг зөрчих тохиолдлуудын талаар дээр тэмдэглэсэн тайлбарыг анхаарч зөв зохистой ярьж, бичиж сурах нь эх хэлний боловсролын нэгэн чухал чадвар болно.

## б) Тийн ялгалын нөхцөлийн найруулга

*Холбоо үг, өгүүлбэр бүтээхэд оролцож жинхэнэ нэрийг бусад үгтэй холбох хэлзүйн айг тийн ялгал гэнэ. Энэхүү хэл зүйн айг илрүүлэх бүтээврийг тийн ялгалын нөхцөл гэж нэрлэдэг.*

Монгол хэлний тийн ялгал:

- нэрлэх(∅),
- харьяалах (-ын/-ийн, -ий/-ы, -н)
- өгөх орших (-д, -т),
- заах (-ыг, -ийг,-г)
- гарах (-аас4),
- үйлдэх (-аар4),
- хамтрах (тай2),
- чиглэх (руу2, -луу2)

Тийн ялгалын нөхцөлийн найруулгад зөв хэрэглэх нь найруулгыг сайн болоход нөлөөлдөг.

## • Заахын тийн ялгалыг буруу залгах алдаа

Нэгдүгээр биеийн төлөөний үгийн өгөх оршихын тийн ялгалын хэлбэрийн үндэс “над” дээр заахын тийн ялгалын -ыг нөхцөл залган, “надыг” гэж болохгүй. Зөвхөн “намайг” гэнэ.

## • Заахын тийн ялгалын тэг хэлбэрийг хэрэглэх.

Заахын тийн ялгалын -ыг/ийг/г нөхцөл болон тэг хувилбарыг зохистой хэрэглэнэ. Тухайлбал, онцолж нэрлэсэн, заасан тохиолдолд үйл үгийн өмнө онцолсон нэрийг-ыг/ийг/г нөхцөл залгана. Жишээ нь: Би ном уншсан. Би тэр номыг уншсан.

## в) Хамаатуулах нөхцөлийн найруулга

*Тухайн зүйл хэний юуны хамаатай болохыг ялган заах үүрэг бүхий нөхцөлийг хамаатуулах нөхцөл гэнэ.*

Хамаатуулах нөхцөлүүдийн үндсэн үүрэг нь бие, эзнийг ялган хамаатуулах хэл зүйн харьцаа заах шинж юм. Эл шинжээр нь хамаатуулах нөхцөлийг биед хамаатуулах, эзэнд хамаатуулах гэж хоёр ангилна.

Биед хамаатуулах нөхцөл нь:

-нэгдүгээр биед хамаатуулах минь (маань)

-хоёрдугаар биед хамаатуулах тань, чинь

-гуравдугаар биед хамаатуулах нь

Эзэнд хамаатуулах нөхцөл нь:

-аа4 болно.

## • Хамаатуулах нөхцөл давтах алдаа.

Нэг үндэстэй биеийн төлөөний нэр (чи, та), хамаатуулах нөхцөлийг (чинь, тань) нэг өгүүлбэрт давтахгүй.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Таны бие лагшин тань тунгалаг уу?”, “Чиний хичээл ном чинь сайн уу?”

Зүй нь: \_\_\_\_\_

“Таны бие лагшин тунгалаг уу?”, “Чиний хичээл ном сайн уу?”, “Бие лагшин тань тунгалаг уу?”, “Хичээл ном чинь сайн уу?” гэж хэлж ярих нь зүйтэй.

## • “нь” давтах алдаа.

Гуравдугаар биед хамаатуулах “нь” нөхцөлийг нэг өгүүлбэрт олноор нурших нь найруулгын чанарыг бууруулдаг. Тийм учраас, зохистой газарт зөв хэрэглэж сурах хэрэгтэй.

Жишээ нь:

“Ерөнхийлөгчийн хэлсэн үг нь УИХ-ын гишүүдийн төсөөлж байснаас нь хол зөрсөн нь тэдний хүлээн авч байгаа байдлаас нь илэрхий байв.” Энэ өгүүлбэрт “нь” нөхцөлийг дөрвөн удаа давтжээ. Ингэж хэрэггүй газарт “нь” нөхцөлийг нуршин хэрэглэх нь найруулгын өнгө аяст сөргөөр нөлөөлөөд зогсохгүй утга агуулгыг ч бүрхэгдүүлэх талтай юм.

Зүй нь:

“Ерөнхийлөгчийн хэлсэн үг УИХ-ын гишүүдийн төсөөлж байснаас хол зөрсөн нь тэдний хүлээн авч байгаа байдлаас илэрхий байв.”

Бас сүүлийн үед сонин хэвлэлд гуравдугаар биед хамаатуулах нөхцөлийг буруу хэрэглэж байна. Энэ нь хар ярианы гажууд үзэгдлийг бичгийн хэлэнд шууд буулгаснаас үүдэлтэй юм.

Жишээ нь:

“Солонгосын визийн хураамжийг банкинд төлж болох нь”, “УИХ-ын дарга удахгүй огцрох нь” гэх мэт.

Зүй нь:

“Солонгосын визийн хураамжийг банкинд төлж болно”, “УИХ-ын дарга удахгүй огцорно” гэж цагаар төгсгөх нөхцөлөөр хэлбэржүүлэн бичих ёстой.

Харин эрдэм шинжилгээний найруулгад үйлийн тодотгон холбох нөхцөлийн араас биед хамаатуулах нөхцөлийг залгаж, бүлэг хэсгийн гарчгийг нэршүүлэн бичдэг онцлог бий.

## 2. Үйл үг хувилахуйн найруулга

Монгол хэлний үйл үг нь хэлний тогтолцоонд чухал үүрэгтэй, хэл зүйн олон үзэгдлийн зангилаа болж байдаг учраас нэр үгээсээ илүү олон хэл зүйн хэлбэр, хувилалтай байна.

### а) Үйл үгийн хэвийн дагаврын найруулга

*Үйл хөдлөлөөс үйлийн эзэн, үйлэнд өртөгч юм хоёрт харьцах харьцааг тогтоох үйл үгийн хэл зүйн айг хэв гэнэ.*

Үйл үгийн дагаврыг үйлийг үйлдэж, үйлэнд өртөж буй эзнээс нь шалтгаалан:

өөрөө үйлдэх  
бусдаар үйлдүүлэх  
бусдын эрхэнд үйлдэгдэх  
хамтран үйлдэх  
харилцан үйлдэх  
олноороо үйлдэх хэв гэж ангилж байна.

### • Бусдаар үйлдүүлэх хэвийг зөв хэрэглэх

Бусдаар үйлдүүлэх хэвийн найруулгад –уул2 дагаврыг шаардлагагүйгээр давтан хэрэглэх алдаа түгээмэл бий.

Жишээ нь: \_\_\_\_\_

Сурагчдаар сандал ширээ зөөлгүүлэв.  
Би Лувсан багшаар монгол хэл заалгуулж байна  
Би дүүгээр цамцаа хатаалгуулсан гэх мэт.

Зүй нь: \_\_\_\_\_

Сурагчдаар сандал ширээ зөөлгөв.  
Би Лувсан багшаар монгол хэл заалгаж байна  
Би дүүгээр цамцаа хатаалгасан гэх мэт.


Түүнчлэн монгол хэлэнд “Нохойд хазуулаад сорвитой болжээ” гэх мэтээр үйлдүүлэх хэвийн дагавар бүхий үг бусдын эрхэнд үйлдэгдэх утга илтгэх өвөрмөц тохиолдол байдаг ажээ.

### • Бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийг зөв хэрэглэх.

Бусдын эрхэнд үйлдэгдэх хэвийн “-гд” дагаврыг бичгийн төдийгүй ярианы найруулгад ч буруу хэрэглэсээр байна.

Жишээ нь: \_\_\_\_\_

Хурал (тэмцээн, уралдаан, барилдаан, хичээл, давтлага, сурталчилгаа, үзлэг, оношилгоо, сонгууль, ажил, бүртгэл гэх мэт явагдаж байна гэж бичиж байгаа нь буруу юм.



Зүй нь: \_\_\_\_\_

Хурал болж байна гэх буюу хуралдаж байна, тэмцээн (уралдаан, сонгууль) болж байна, бөх барилдаж байна, давтлага (сурталчилгаа, үзлэг, оношилгоо) хийж байна гэх мэтээр үйл үгийн идэвхтэй



хэвээр найруулж бичих нь монгол найруулгын хэм хэмжээнд нийцнэ.

Мөн зарим түгээмэл тохиолдлыг залруулах үлгэртэй нь харьцуулан үзүүлье.

жишээ нь: \_\_\_\_\_

Зүй нь: \_\_\_\_\_

сонины захиалга явагдаж байна  
үдэшлэг зохиогдов  
төсөвт тусгагдаагүй  
шалгалт явагдаж байна  
тавигдсан шаардлага дагуу  
албан газраас зөвшөөрөгдсөнөөр  
олонхын саналаар дэмжигдэв  
залруулга сонинд нийтлэгджээ

сонины захиалга авч байна  
үдэшлэг хийв /зохиов/  
төсөвт тусгаагүй  
шалгалт авч байна  
тавьсан шаардлагын дагуу  
албан газрын зөвшөөрснөөр  
олонхын саналаар дэмжив  
залруулга сонинд нийтэлжээ

Үйлдэгдэх хэвийн дагаврыг илүү буюу оновчгүй хэрэглэснээс найруулга сулардаг боловч зайлшгүй хэрэглэх дараах тохиолдол бий.

1. Хүний мэдрэхүйд аяндаа өртөн тусч буй юм үзэгдлийг заан өгүүлэхэд хэрэглэнэ. Жишээлбэл бодогдох (сэтгэлд), сонстох, харагдах, үзэгдэх, баригдах (гарт), мэдрэгдэх, тэмтрэгдэх гэх мэт.

2. Тухайн үйлийг хийж гүйцэтгэхэд хүч мөхөстөх, гаднын нөлөө бусдын давамгай хүч чадал, зүй тогтлын эрхэнд болохыг заахад хэрэглэнэ. Жишээлбэл дайнд ялагдах, зовлонд нэрвэгдэх, нохойд хөөгдөх, өрөнд баригдах, салхинд туугдах, тоглоомд хожигдох, үерт автах, цасанд дарагдах гэх мэт.

3. Албан бичгийн найруулга, шинжлэх ухааны нэр томъёо зэрэгт үйлдэгдэх хэвийг хэрэглэдэг уламжлалтай. Жишээлбэл мэдэгдэл, хуваагдагч, нэмэгдэгч, өгүүлэгдэхүүн, мэдэгдэхүүн гэх мэт.

Эдгээрээс өөр тохиолдолд үйлдэгдэх хэвийн дагаврыг аль болох хязгаартай хэрэглэвэл зохино.

### • Хамтран үйлдэх хэвийг зөв хэрэглэх

Энэ хэв нь тухайн үйлийг хоёр ба түүнээс олон эзэн хамтран үйлдэх утга илтгэдэг. Аливаа үйлийг хамтран хийх утгыг үйл үгийн үндсэнд -лц дагавар залгаж илэрхийлнэ. Хэлэлц-, харилц-, оролц-, ярилц-, солилц- гэх мэт.

Хамтран үйлдэх хэвийн дагавартай холбоотой найруулгын алдаа харьцангуй бага гардаг. Гэхдээ нэг өгүүлбэрт -лц дагаврыг олон давтсан, нэг эзний үйлэнд –лц дагавар илүү хэрэглэсэн алдаа тохиолдоно. Ийм алдааг засахад илүү орсон үйлдэлцэх хэвийн дагаврыг хасаж найруулна. Зарим үйлдэлцэх хэвт үйлийг нэг эзний талаас найруулах боломжтой.

Жишээ нь: \_\_\_\_\_

Болд МУИС-д суралцаж байлаа.

Зүй нь: \_\_\_\_\_

Болд МУИС-д сурч байлаа.

### • Харилцан үйлдэх хэвийг зөв найруулах

Хоёр ба түүнээс дээш эзэн оролцож, үйлийг харилцан гүйцэтгэх санааг илтгэсэн үйл үгийн хэлбэрийг хэлнэ. Аливаа үйлийг харилцан үйлдэх утгыг үйл үгийн үндсэнд –лд дагавар залгаж илэрхийлнэ. Жишээлбэл бөх барилдах, хүүхэд ноцолдох, морь уралдах гэх мэт.

Харилцан үйлдэх хэвийн дагавартай холбоотой найруулгын алдаа харьцангуй бага боловч тус хэвийн дагаварт үгийн үйлийн эзнийг олон тооны дагавраар хэлбэржүүлсэн алдаа гардаг байна.

Жишээ нь: \_\_\_\_\_

Үзүүр түрүүний бөхчүүд барилдаж эхэллээ.

Энэ үеэр 6 насны морьд уралдаж, хүчит 32 бөх барилдсан юм.

Зүй нь: \_\_\_\_\_

Үзүүр түрүүний бөх барилдаж эхэллээ

Энэ үеэр 6 насны морь уралдаж, хүчит 32 бөх барилдсан юм.

### • Олноороо үйлдэх буюу үйлдэцгээх хэвийг зөв хэрэглэх

Энэхүү хэв нь аливаа үйлийг олноороо үйлдэх утгыг илтгэх бөгөөд үйл үгийн үндсэнд -цгаа (-цгээ, -цгоо, -цгөө) дагавар залгаж илрүүлнэ. Дасгалаа хурдан хийцгээ гэх мэт.

Олон эзэн гүйцэтгэж буй үйлд онцын шаардлагагүй үед олноороо үйлдэх хэвийн дагавар залгах найруулах алдаа түгээмэл гардаг. Ийм алдааг засахдаа өгүүлбэрт тодорхой үүрэггүй үйлдэлцэх хэвийн дагавар юм уу, эсвэл үйлийн олон эзнийг хасан найруулна.

Жишээ нь: \_\_\_\_\_

Тэд их л шаргуу ажиллацгааж байлаа.  
... гэрээнд талууд гарын үсэг зурцгаасан билээ.

Зүй нь: \_\_\_\_\_

Тэд их л шаргуу ажиллаж байлаа.  
...гэрээнд гарын үсэг зурцгаасан. / талууд гарын үсэг зурсан.

## **б) Үйл үгийн байдлын дагаврын найруулга**

*Тодорхой цаг хугацааны дотор үйл хөдлөл хэрхэн болж байгааг илэрхийлдэг хэл зүйн айг байдал гэнэ.*

### **• Түр үйлдэх байдал**

Үйл үгийн үндсэнд –зна4 дагавар залгаж тухайн үйлийг хоромхон зуур үйлдэх байдлын утга илэрхийлнэ. Түр зуур үйлдэж буйг илэрхийлэх “түр” “жаахан” гэсэн үгсийн хамт –зна4 дагавар давхар ашиглахгүй.

Жишээ нь: \_\_\_\_\_

“Та жаахан хүлээзнэ” гэхэд -зна дагавраас гадна “жаахан” гэдэг үг түр үйлдэх утга илтгэдэг учир хэлний хэмнэлтийн зарчим харшилсан алдаа гэж үзнэ.

Зүй нь: \_\_\_\_\_

“Та жаахан хүлээ”, “Та хүлээзнэ” гэж хоёр янзаар илэрхийлж болох аж.

### **• Бүр мөсөн үйлдэх байдал**

Үйл үгийн үндсэнд –чих(-ч) дагавар залгаж тухайн үйлийг бүр мөсөн үйлдэх байдлын утгыг илтгэнэ. Ярианы хэлэнд -чих дагаврын “х”-г хурааж, “Би Сэлэнгэ явчаад ирлээ.” гэх мэтээр хэрэглэдэг.

Сүүлийн үед ярианы хураангуй хэлбэрийг бичгийн хэлэнд, нэн ялангуяа нийгмийн мэдээллийн сүлжээгээр түгээмэл ашиглаж буй. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн нягт нямбай, итгэл үнэмшилтэй байдлыг хадгалах үүднээс ярианы биш, бичгийн хэлбэрийг ашиглахад анхаарах нь зүйтэй.

Жишээ нь: \_\_\_\_\_

Нэг сонгогч гэрийн хаяг дээр нь 3 хүн нэмэгдсэн, бас саналаа өгчөөд явцан байна гэлээ.

Зүй нь: \_\_\_\_\_

Нэг сонгогч гэрийн хаяг дээр нь 3 хүн нэмэгдсэн, бас саналаа өгчихөөд явсан байна гэлээ.

## в) Холбох нөхцөлийн найруулга

Монгол хэлний үг зүйн тогтолцоонд үйл үгийг бусад үгтэй холбодог бүлэг нөхцөл байх бөгөөд тэдгээр нь үйлийг үйлтэй, үйлийг нэртэй холбох үндсэн үүрэгтэй. Үйлийг нэр үгтэй холбодог -х, -гч, -даг, -аа(гүй), -сан, -маар зэрэг нөхцөл буй. Жишээлбэл “Уух цай, уншигч хүн, хэлдэг үг, хийгээгүй ажил, сурсан ном, дуулмаар дуу” гэхчлэн эдгээр нөхцөлөөр хэлбэржсэн үйл үг нь нэрийг тодотгодог ажээ.

### • Хамын “-н” зөв хэрэглэх

Үйлийг үйлтэй холбох үүрэг бүхий хамын -н нөхцөлөөр хэлбэржсэн үйл үндсийг нэр үгтэй холбож, тодорхой нэрлэлт үүсгэх зүй бус үзэгдэл нэлээд гарч байна.

Жишээ нь: \_\_\_\_\_

Дахин шалгалт, нөхөн сонгууль, бүтээн босголт, зохион байгуулалт, хянан шалгалт, хүлээн авалт гэх мэт.

Зүй нь: \_\_\_\_\_

Хэл зүйн зүй тогтлоор эдгээр үг нь дахин шалгах, нөхөн сонгох, бүтээн босгох, зохион байгуулах, хянан шалгах зэрэг үйлийн холбоо үг байх ёстой.

Сүүлийн үед радио телевиз, сонин сэтгүүлээр “давтан зээл” гэж сурталчлах болсон нь уг ташаарал улам газар авсны тод илрэл юм.

Таны 4 боломж.

- Ажлын 8 цагт зээл авах боломж,
- Давтан зээлийн хэмжээ өндөр,
- Банкны хяналтын үнэлгээ 70%

Эрдэмтэн, профессор Ц.Шагдарсүрэнгийн дурдсанчлан:

Монгол хэлэнд “...сүүмийн сүүмийн харагдах нь...”, “...тахин шүтэх...”, “...албан үүргээ урвуулан ашигласан байна...” гэх мэтээр “-н”-ээр төгсөж, хам утга илэрхийлдэг нөхцөл үйлийн дараа үйл үг, үйлт нэр л орохоос биш, нэр үг ордоггүй. Монгол хүн идэн хоол, суун жаргал гэдэггүй атлаа яагаад нөхөн сонгууль, дахин хуралдаан... гэх болов? гэсэн байна.

# ҮГИЙН САНГИЙН НАЙРУУЛГА БА ОНЦЛОГ

*Аливаа хэлний бүх үгийг нийтэд нь тухайн хэлний үгийн сан гэдэг. Манай монгол хэлний бүх үг нийлээд монгол хэлний үгийн сан буюу үгсийн бүрэлдэхүүн болно.*

Үгийн сангийн бүрэлдэхүүн болох ойролцоо утгат үг хэллэг, эсрэг утгат үг хэллэг, ижил үг, олон утгатай үг, хуучин үг, шинэ үг, харь үг, нутгийн аялгууны үг, цээрлэн эерүүлсэн үг хэллэг, этгээд үг хэллэг, мэргэжлийн үг, нэр томьёо зэргийн найруулгын үүрэг, ач холбогдол, тэдгээрийг солин найруулах боломжийн талаар товч өгүүлье.

## Харь үгийн найруулгын онцлог

*Монгол бичгийн болон ярианы хэлэнд найруулгынх нь төрлөөс шууд хамаарч харь хэлний үгийг хэрэглэх хэм хэмжээ янз бүр байдаг.*

Сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэл найруулгад харь хэлнээс гаралтай үгсийг бусад салбараас түгээмэл хэрэглэдэг онцлогтой. Зах зээлийн эдийн засагт шилжиж гаднын олон оронтой улс төр, соёл урлаг, шинжлэх ухаан техник, эрүүл мэнд, санхүү эдийн засаг, ахуй амьдралын хүрээнд хүртэл чөлөөтэй харилцах болсноор монгол хэлний үгийн санд хуулбарлан орчуулсан үг олон болсоор байгааг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслийн хэл найруулгаас төвөггүй харж болно.

Харь үг хэллэгийг бүрэн ба заримдаг гэсэн хоёр хэлбэрээр хуулбарлахаас гадна үгчлэн орчуулж хэрэглэх нь их ч байна.

## Бүрэн хуулбарласан үгсийн жишээ

пентатоник - таван эгшигт, аллергия - харшил, рейтинг - чансаа, проблем - асуудал, бонд - үнэт цаас, маркетинг - зах зээл судлал, formal education - албан боловсрол, informal education - албан бус боловсрол, whole prices - бөөний үнэ, social protection - нийгмийн хамгаалал, pressure group - сонирхлын бүлэг, нормы социальные - нийгмийн хэм хэмжээ, охрана труда - хөдөлмөр хамгаалал, гуманизм - энэрэнгүй үзэл, гуманитарная помощь - хүмүүнлэгийн тусламж гэх мэт.

## **Заримдаг хуулбарлан орчуулсан үгсийн жишээ**

сонгуулийн компани, хөгжлийн агент, гэрээт диллер, улс төрийн императив, ардчиллын индекс, сонирхлын артикуляци, сонирхлын агрегаци, боловсролын стандарт, хувийн сектор, жендерийн асуудал, бизнес орчин, элитийн онол, экологийн хөдөлгөөн, академик боловсрол, менежментийн сургалт гэх мэт.

## **Үгчлэн орчуулсан харь үгсийн жишээ**

нэрийн хуудас, бялуу хуваах, загалмайлсан эцэг, гар утас, тэргүүн хатагтай гэх мэт.

Монгол хэлэнд орсон харь үгийг хэл найруулгад ямар хэмжээгээр хэрхэн найруулахыг тодорхойлохдоо монгол хэлний найруулгын онцлог, уламжлалыг харгалзах учиртай. Харь үгийг их хэрэглэх нь эх хэлний найруулгын өвөрмөц онцлог, яруу сонсголон, ойлгомжтой энгийн шинжид харшилдаг болохыг ямагт санаж уугуул монгол үгээрээ оноох, нэрлэх, орчуулан хэрэглэх боломжтой үед эх сайхан монгол хэлнийхээ үг хэллэгээр ярьж бичиж байхыг эрхэмлэвэл зохино.

Жишээлбэл:

аудит - санхүүгийн хяналт, хөндлөнгийн хяналт шалгалт,  
аудитор - хянан шалгагч,  
дистрибьютер - гэрээт борлуулагч,  
инфляц - ханш уналт,  
лидер - манлайлагч,  
ломбард - барьцаат зээл,  
маркетинг - зах зээл судлал,  
сенсаци - шуугиан, дуулиан,  
спонсор - ивээн тэтгэгч,  
тендер - сонгон шалгаруулалт,  
фанат - бишрэн шүтэгч, хэт бишрэгч,  
фракц - бүлэглэл,  
и-мэйл - цахим шуудан,  
комикс - цуврал зураг,  
лого - таних тэмдэг,  
массаж - иллэг,  
меню - цэс,  
модерн - орчин үеийн,  
оффис - албан тасалгаа гэх мэтээр хэрэглэж болно.

## Хуучирсан үгийн найруулгын онцлог

*Орчин цагийн ярианы хэлэнд хэрэглэхээ болиод тухайн ард түмэн нь бараг ойлгохгүй болсон үг хэллэгийг хуучирсан үг гэдэг.*

Нэгэн цагт хуучирсан үг эргээд идэвхтэй үгийн санд орж хэрэглээ нь өргөжих тохиолдол элбэг байдаг. Өөрөөр хэлбэл хуучирсан үг хэллэгийг огт хэрэглэхгүй гэсэн үг биш билээ. Харин ч хуучирсан үг хэллэгийг дахин сэргээн хэрэглэснээр зарим хуучин үг хэллэгүүд өнөө үед утга шинэчлэгдэн үгийн санг улам баяжуулж байдаг билээ.

**Жишээ нь:**

түнш, зиндаа, хатагтай, дамжаа, барьцаа, цагаачлах, хандив, баалах, дэнчин, бооцоо, хүлцэл өчих, хахууль, гувчуур, цааргалах, тооцоо, түрээс, төрийн соёрхол, хуралдай, айлдвар гэх мэт олон үгийг өдөр тутмын ном хэвлэл, сонин сэтгүүлээс харж болно.

Түгжрэл гэсэн үгийг өмнө нь анагаах ухааны нэр томьёонд л хэрэглэж байлаа. Харин сүүлийн үед автомашин олширсноос замын хөдөлгөөн саатахыг түгжрэл гэх болжээ.

## Шинэ үгийн найруулгын онцлог

*Ярианы буюу бичгийн хэлэнд урьд өмнө байгаагүй шинээр бий болсон үг хэллэгийг шинэ үг гэдэг.*

Шинэ үг хэллэг үүсэн бий болох нь үгийн санг баяжуулж байдаг голлох хүчин зүйл билээ. Нийгмийн хөгжил өөрчлөлт ихтэй байхын хамтаар шинэ үг бий болох үйл явц нь дагаад эрчимтэй байдаг. Гэвч шинэ үг хэллэг нь үүссэн даруйдаа утга зохиолын хэлэнд хэвшин толь бичигт тэмдэглэгдэн түгээмэл хэрэгцээтэй үг болдоггүй онцлогтой. Бидний амьдралд урьд өмнө байгаагүй зарим нэг цоо шинэ юм үзэгдэл, ойлголт ухагдахууныг нэрлэхдээ тухайн хэлээр нь шууд нэрлэх (компьютер, таблет, фэйсбүүк), эсвэл орчуулан шинэ үгээр нэрлэн (smart phone – ухаалаг утас, twitter - жиргээ) шинэ үгийг хэрэглээнд нэвтрүүлдэг.

Ойрмогхон бий болсон “олон намын тогтолцоо, улс төрийн суулт, ажил хаялт, хувьчлал, түрээс, зээл тусламж, лидер, элит, терроризм, төрийн өмч, шоу, тендер, лизинг, бакалавр, магистр” гэх мэт шинэ үгс ч түгээмэл хэрэглээний үг болжээ. Хэлэнд шинэ үг энэ мэтээр тасралтгүй

бий болсоор байдаг байна. Үгийн санд шинээр орж ирсэн үг, тэр үгийг хэрэглэх хүмүүсийн хүрээнд ердийн үг шиг идэвхтэй хэвшсэн цагт шинэ үг байхаа болино.

**Жишээ нь:**

туйлшрал, ядуурал, сонгуулийн тойрог, зах зээл, тойрон хүрээлэгчид гэх мэтийг дурдаж болно.

Сүүлийн жилүүдэд монгол хэлний үгийн санд үг зүйн аргаар буюу дагавар залгаж үүсмэл шинэ үг бүтэх: “хувьчлал, хувьцаа, түгжрэл, түрээс, эрсдэл, намчирхах”, хоёр үг нийлсэн: “ажил хаялт, дуудлага худалдаа, өмч хувьчлал, фото шуудан, хоспис эмчилгээ”, мөн найрч холбогдсон шинэ нийлэмж үг: татварын бойкот, сонгуулийн давалгаа, ургийн сургалт, зэрэг аргаар шинэ үг үүсэж байгааг сонин сэтгүүлийн найруулгаас харж болно.

Шинэ үг хэллэг тодорхой мэргэжлийн утга зохиолын хэлэнд үүсээд, тухайн мэргэжлийн хэл найруулгад хэрэглэгдэж явсаар аажмаар нийт утга зохиолын хэлэнд орж хэвшдэг онцлогтой. Сүүлийн үед үүссэн шинэ үг хэллэгийг ажиглахад ихэнх нь сонин сэтгүүлийн найруулгаар дамжин дэлгэрч байгаа тал ажиглагдаж байна.

## **Нутгийн аялгууг сэтгүүлзүйд бичвэрт ашиглах нь**

*Нийтийн утга зохиолын хэлэнд түгээмэл хэрэглэдэггүй зөвхөн нэг бүс нутаг, тухайн бүс нутгийн аман аялгуу, салбар аман аялгуугаар хэлэлцэгчдийн хэл ярианд тохиолдох үгийг нутгийн аялгууны үг гэдэг.*

Жишээ нь: мэлхий гэхийг буриад аялгуунд баха, тэнэг гэхийг уймар, базаахгүй, муухан гэхийг тулиур, ухна гэхийг тэх, эцэг гэхийг баавай, харах гэхийг ойрд аялгуунд халиах, өглөө гэхийг өрүүн, маргааш гэхийг ойрд аялгуунд мангадар, үзэмчин аялгуунд магаатар, олон гэхийг дариганга аялгуунд бяцхан, том гэхийг агдан, хомоолыг дархад аялгуунд тэвээ, бугуйвчийг богоон, малтуурыг хошиг, тооныг дөрвөд аялгуунд хараач, хатавчийг багс, тэрлэгийг лавшиг гэх мэтээр нэрлэдэг.

Нутгийн аялгууны үг нийтийн хэлний үгийн санг баяжуулдаг билээ. Нөгөө талаар нэг бүс нутгийн цөөн хүний эрхэлдэг аж ахуй, зан заншилтай холбоотой байдаг учир бусдад ойлгомжгүй, нийтийн хэлэнд оруулахад тохиромжгүй зүйл бас байх аж. Тиймээс нутгийн аялгууны үгийг сэтгүүлзүйн бичлэгт, ялангуяа мэдээлэх төрөл зүйлд шууд хэрэглэхгүй.



Харин сурвалжлага, хөрөг, ярилцлага зэрэг төрөл зүйлд тухайн хүн, орчин нөхцлийн онцлог шинжийг тод томруун харуулах зорилгоор ишлэл болгож ашигладаг.

## Нэр томьёо, мэргэжлийн үг хэллэгийн найруулгын онцлог

Нэр томьёоны зүйл нь ажил мэргэжлийн хувьд хязгаарлагдмал хэрэглэгддэг бөгөөд үүгээрээ мэргэжлийн үг хэллэгтэй ойролцоо байдаг билээ. Нэр томьёо албан ёсны, нийтээр заавал дагах шинжтэй, ухагдахууныг шинжлэх ухааны үүднээс тайлбарласан байдаг бол мэргэжлийн үг хэллэг нэг мэргэжлийн хүмүүсийн ярианы хэлэнд тархсан, албан ёсны бус үг хэллэг байдаг билээ.

*Шинжлэх ухаан, техник технологийн болон улс төр, нийгмийн салбарт тогтвортой нэг утгаар хэрэглэгдэх, ихэнхдээ тусгай тогтоосон үгийг нэр томьёо гэнэ.*

Жишээ нь:

Хүчил, исэл, онол, атом, уураг, их хурал, давс гэхэд эдгээр үгс тухайн шинжлэх ухааны салбартаа нэр томьёо болно.

Бидний өдөр тутмын харилцаанд өргөн хэрэглэгдэж буй зарим харь хэлнээс олж ирсэн нэр томьёог түүвэрлэн шинжлэх ухааны салбар бүрээр ангилан жагсаавал:

1. Улс төрийн салбарт:

авторитаризм, агент, агентлаг, аллерги, аудит, блиц, кайф, карьер, интеграци, имиж, институт, коррупци, либерал, мафи, прагматик, рекэт, риск, статус гэх мэт.

2. Санхүү, эдийн засаг, зах зээлийн салбарт:

авизо, аутсайдер, аукцион, бизнес, бирж, брэнд, бонд, лого, маркетинг, менежер, концерн, трейд, супермаркет, популист гэх мэт.

3. Соёл урлаг, шинжлэх ухаан, боловсролын хүрээнд:

альтернатив, анонс, дебют, дизайн, караоке, хип-хоп, фен, магистр, бакалавр, тендер, тест гэх мэт.

4. Техник, технологи, олон улсын хэвлэл мэдээллийн салбарт:

патент, лиценз, скайннер, принтер, диск, хард, маус, дижитал аппарат, мессеж, мессенжер, хакер гэх мэт.

5. Биеийн тамир, спорт, эрүүл мэндийн салбарт:

олимп, спорт, боулинг, бейсбол, гольф, тернажёр, сумо, башё, секс,

сексологи, клонаци, альцгеймер гэх мэт байгаагаас нийгэм улс төрийн салбарт хамгийн олон нэр томъёо үүсэн бий болж байгааг харж болно.

Сэтгүүлчид тухайн мэдээллийг дундаж иргэн, энгийн хэрэглэгчдэд ойлгомжтой байдлаар хүргэх үүрэгтэй учир мэргэжлийн нэр томъёо, үг хэллэгийг тайлбарлаж, энгийн ярианд хөрвүүлж хэрэглэх учиртай. Орчин үеийн сонин нийтлэл, хэвлэл мэдээллийн хэл найруулгад түгээмэл хэрэглэгдэж буй нэр томъёоны бүрэлдэхүүнийг ажиглавал, тухайн нийлмэл нэр томъёоны аль нэг, эсвэл үгийг урьд өмнө нь хэрэглэгдэж байсан үгтэй холбон найруулж нийлмэл шинэ нэр томъёо бүтээх үзэгдэл түгээмэл болж байна.

**Жишээ нь:**

нийгмийн ухамсар, нийгмийн бодлого, нийгмийн хамгаалал, хүний хэрэгцээ, эмзэг бүлэг, сэтгэлзүйн дарамт, нийгмийн халамж, сэтгэцийн эрүүл мэнд, улс төрийн орчин, олон нийтийн оролцоо, гэр бүлийн хүчирхийлэл, хувь хүний үйл ажиллагаа, хүний хэрэгцээ, хөрөнгийн бирж, хуулийн төсөл, сонгуулийн тойрог, иоджуулсан гурил, магадлан итгэмжлэх, гэрээт ажилтан, нөхөн сонгууль, хувьцаа эзэмших гэх мэт.

Эдгээр үгийн олонх нь нийгэм улс төр, эдийн засгийн холбогдолтой нэр томъёо байгаагаас үзэхэд үг нийлэх аргаар шинэ нэр томъёо бүтэх арга голлож, нөгөө талаас нийлмэл нэр томъёо нь ухагдахуунаа илүү оновчтой илэрхийлж байна гэж үзэж болно.

## **Этгээд үгийн найруулгын онцлог**

Этгээд үг хэллэгийн найруулгын хэрэглээний зорилго нь хэл ярианд тогтсон нэг хэвийн өнгө маяг, хэлбэр журмыг өөрчилж хэл яриагаа хөнгөн хөгжүүн болгох, санаагаа бусдаас нуух, бүдүүлэг болон доромж аяс гаргах зэрэгтэй холбоотой хэлэнд бий болж, тухайн үүрэг нь үгүй болоход хэрэглээнээс гарч байдаг байна.

Тухайн хэлээр ярилцагч хүмүүсийн ажил мэргэжлийн онцлог, нас хүйс, нийгмийн байдал, мэдлэг боловсролын түвшний ялгааг илтгэж байгаа нь этгээд үгийн хэрэглээний түвшин, онцлогийг харуулна. Этгээд хэллэг нь нийтэд түгэн тархсан байдлын хувьд харилцан адилгүй байдаг. Нэг хэсэг этгээд хэллэг нь олон нийтийн дунд идэвхтэй хэрэглэгдэж утга зохиолын хэлний үгийн санд хүртэл ордог бол зарим нь маш явцуу хүрээний дунд хэрэглэгддэг.

Жишээ нь: \_\_\_\_\_

гол гаргах - залилах, буу халах - дэмий чалчих,  
бонустай хүүхэн - дагуул хүүхэдтэй эмэгтэй  
гэх мэт үгс хүмүүсийн дунд маш идэвхтэй хэрэглэгддэг бол  
Цагаан уулын бэл рүү явах - амиа хорлох, дүүгээ дуудах - өрөөнд  
нь шинэ хоригдол ирэхийг хүсэх, кааш - шинэ ялтан, бөөр -  
шоронгийн газрын харуул гэх мэт үгс нь зөвхөн шоронгийнхны  
дунд хэрэглэгддэг тул маш явцуу хэрэглээтэй хэвээр ажээ.

Тэгэхдээ ийм этгээд үг хэллэг тухайн хэлний үг хүрэлцээгүйгээс  
болж үүсдэггүй, зөвхөн эх хэлээ ямар нэг хэмжээгээр гуйвуулсан этгээд  
маяг, нууцлах гаж сонирхол зэргээс үүсдэг тул бүх нийтийн өргөн  
хэрэглээний үг болохгүй, олон нийтэд ойлгомжгүй байдаг. Тийм ч учраас  
сэтгүүлзүйн бичвэрт этгээд үг хэллэгээс татгалзах нь зүйтэй. Зөвхөн хөрөг,  
ярилцлагын төрөл зүйлд тухайн хүний хэв шинж, зан байдал, хувь үний  
онцлогийг тодруулан харуулах зорилгоор ишлэж ашиглах нь зохистой.

## Ойролцоо үгийн найруулгын онцлог

Гол утгаараа ойролцоо үгсийг үгсийн сангийн ойролцоо үг гэдэг.  
Эдгээр үгс нь хам сэдэвт бие биеэ орлох боломжтой байдаг.

Жишээ нь: \_\_\_\_\_

Чагнах - сонсох, үүд - хаалга, гэр - өргөө, харах - үзэх, айл - өрх  
гэх мэт.

Үгийн сангийн ойролцоо утгат үгсийг хоршин хэрэглэх нь түгээмэл  
байна.

Жишээ нь: \_\_\_\_\_

угаах цэвэрлэх, цэрэг цуух, туслах дэмжих гэх мэт.

*Найруулга болон хэрэглээний үүднээс нэг утгыг өөр өөрөөр  
нэрлэсэн үгсийг найруулга зүйн ойролцоо үг гэдэг.*

Ойролцоо утгатай үг хэллэгийн найруулгын үүргийг онцлон  
анхаарч хамгийн тохиромжтойг нь олж сонгохыг чухалчилдгаараа  
найруулга зүйн гол асуудал гэж ч болох юм.

Жишээ нь: \_\_\_\_\_

Хүүхдийн үсийг хүндэтгэлийн найруулгаар даахь,

дээл хувцсыг нь баринтаг гэх бөгөөд аливаа хүндэт зочны ирэхийг айлчлах, явахыг мордох гэх мэт.

Юуны урьд ойролцоо утгат үгийг сонгож найруулахад:

1. Албан бичгийн, сонин сэтгүүлийн, эрдэм шинжилгээний, уран зохиолын, ярианы гэх мэт утга зохиолын хэлний найруулгын төрөл,

2. Эрхэмсэг буюу дээд, ерийн буюу дунд, доод буюу доромж гэх мэт найруулгын зэрэг,

3. Шоглосон, энхрийлсэн, егөөдсөн гэх мэт найруулгын өнгө аясыг анзаарч найруулах нь чухал. Тухайлбал, ойролцоо утгат үйл үгийн хэрэглээний онцлогийг найруулгын гурван зэргээр ялгаж үзвэл:

<b>Эрхэмсэг буюу дээд</b>	<b>Ерийн буюу дунд</b>	<b>Доромж буюу доод</b>
зооглох	идэх	гудрах, цуслах
нойрсох	унтах	ногоорох, ширгэх
айлдах	хэлэх	чалчих, донгосох
морилох	явах	сажлах
мутарлах	бичих	сараачих

Ойролцоо утгат үгс нь дан үгээр илрэхээс гадна холбоо үгээр, хоршоо үгээр, хэлц хэллэгээр хүртэл илэрнэ. Жишээ нь: баярлах - хөөрөх, баясан догдлох, магнай нь тэнийх, хөл нь газар хүрэхгүй байх гэх мэт.

Энэ мэтээр монгол хэл бол ямар нэгэн утга санааг илэрхийлэх ойролцоо утгат үг хэллэгээр тун ч баян бөгөөд хэрэглэгчийн найруулгын үр чадварыг сориход чухал үүрэгтэй юм. Ойролцоо утгат үгсээс аль оновчтойг зөв сонгон найруулснаар үгийн утгын нарийн ялгамжааг илэрхийлж, нэг үгийг ойр ойрхон давтахаас зайлсхийх нөхцөлийг бүрдүүлэх бөгөөд найруулгыг уран яруу, утга төгөлдөр болгох чухал хэрэглүүр болдог ажээ.

## **Эсрэг үгийн найруулгын онцлог**

Эсрэг үгийг албан харилцаа, сэтгүүлзүй, эрдэм шинжилгээний бүтээл гэх мэт найруулгын төрөл бүрд хэрэглэх боловч голдуу уран зохиолын, ярианы найруулгад юм үзэгдэл, үйл хөдлөл, шинж чанарын эрс тэс ялгааг үзүүлэх зорилгоор ашиглах нь илүү түгээмэл байна. Сэтгүүлзүйн бичвэрт хөрөг, өгүүлэл, сурвалжлагын төрөлд нөхцөл байдлыг тод томруун харуулах үүрэг бүхий эсрэг утгат үг ашигладаг.

## Эсрэг үгийн жишээ:

“Энэ завсар Дагданы эхнэрийн таргалсан, Цэрмаагийн турсан хоёр яг тэнцэнэ” (Д.Нацагдоржийн “Цагаан сар ба хар нулимс”)

Аливаа эсрэг утгат үгийг оновчтой зөв сонгосноороо үзэгдэл юмсын зөрчилтэй, ялгаатай талыг зэрэгцүүлэн тавьж, тодруулан дүрслэх хэрэглүүр болдог.

Эсрэг үг нь найруулгыг уран яруу, утга төгс болгохын хамт өгүүлэгчийн сэтгэлийн өнгө аяс, үнэлэмж хандлага, тухайн үндэстний соёл уламжлал, танин мэдэхүйн сэтгэлгээний онцлогийг илэрхийлдэг учир сэтгүүлзүйн мэдээлэх зорилго бүхий бичлэгийн төрөл зүйлд ашиглах нь тийм ч тохиромжтой биш.

## Ижил үгийн найруулгын онцлог

*Утга өөр боловч хэлбэрээрээ таарах үгсийг ижил үг гэдэг.*

Хэлний түг түмэн үгийн дотор хэлэхэд дуудлага ижил авч ухаарахад утга санаа өөр үгс түгээмэл бий. Тухайлбал, “ав” гэвэл “авах өгөх”-ийн “ав” уу, “ан ав”-ын “ав” уу, “дал” гэхэд “далын тоо”, “далны яс”, “дал мод”, “дал саравч”-ны аль нь вэ, аль (асуух төлөөний үг) дал?, далаа аль (өг)! гэх мэтээр бидний өдөр тутмын хэл ярианд хэдэн зуун ижил дуудлагатай үг хэрэглэгдэж байдаг.

Дангаараа ямар утга санаа илэрхийлж буй нь тодорхойгүй, давхар өөр үгтэй холбогдож аман яриа, хам бичвэрт орж байж хоёрдмол утга нь үгүй болж, сая танигдана. Ийм үгсийг ерөнхийд нь ижил үг хэмээн нэрлэдэг. Ижил үгийг дуудлага, бичлэгийн хэлбэр, хэлзүйн хувилал зэргийг нь харгалзан бүрэн ижил үг, заримдаг ижил үг гэж ангилдаг. Ижил үгийг сайн мэдсэнээр хэл ярианы баялагт нэн тустай бөгөөд зөв сайхан найруулахад анхаарах хэрэгтэй юм.

## Жишээ нь:

“Таг” гэсэн үгийн ижил нэрийг жагсаавал:

1. Хавхаг-данхны таг, авдрын таг, тогооны таг, таг таглах
2. Уул нурууны орой бие-тагийн хөвд, тагийн амьтад, цаатангууд тагаар нутагладаг,
3. Тагт ургасан арц нэг ногоон

Талд ургасан зээргэнэ нэг ногоон

Тайгад ургасан хуш нэг ногоон

4. Хүч нэмэгдүүлэх үг-таг дүлий, таг сохор, таг зогсох, таг болох гэх мэт.

## Олон утгат үгийн найруулгын онцлог

*Нэг үг хоёр болон түүнээс дээш утга илэрхийлж байвал түүнийг олон утгат үг гэдэг билээ.*

Утга зохиолын хэлэнд олон давтамжтай, хэрэглээ ихтэй үг салаа олон утгатай байна.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“Толгой” хэмээх үгийн үндсэн утга нь “биеийн эрхтний нэр” бөгөөд “тэргүүн, шилдэг, эх эхлэл, орой” зэрэг бусад утга нь үндсэн утгаас салбарласан салаа утгууд болно.

Олон утгат үг аль утгаараа хэрэглэгдэж буйг холбоо үг, хам сэдвийнх нь хүрээнд хялбархан таньж болно.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

“хар” гэдэг үгийг сонсоход бараан өнгө сэтгэлд бууж байгаа явдал бол энэ үгийн гол утга тэр бөгөөд түүнээс гадна энэ үг янз бүрийн олон утгаар хэлэнд хэрэглэгддэг. Үүнд: хар даавуу, хар өмд, хар үнэг, хар тогоруу, хар талх гэвэл өнгө заасан утга байна. Хар шуурга, хар хэл ам, хар дарах, хар ажил, хар муйхар, хар буух гэвэл өнгө биш харин тохьгүй тааламжгүй явдал, байдлыг заасан утга байна. Гэтэл хар мөрөн, хар тэнгис, хар мод, хар шөл гэвэл ямар нэгэн хольцгүй дан юм гэсэн утгатай нэр болж байна.

Олон утгат үг, ижил үгийг хуулийн хэл найруулгаас бусад төрлийн найруулгад өргөн хэрэглэдэг. Учир нь хуулийн хэл найруулгад эдгээр үг нь найруулгыг бүрхэгдүүлэх буюу хоёрдмол санаа төрүүлж болзошгүй байдаг аж.

## Хэлц үгийн найруулгын онцлог

Аль ч хэлний хэлц үг тухайн хэлнийхээ найруулгын охь шим, яруу илэрхийлэх хэрэглүүр болж байдаг байна. Хэлц үг нь хүний санаа бодлыг яруу тод уран дүрслэлтэй, товч тодорхой, хэдий хийсвэрлэн хэлж

буй ч гарт баригдаж, нүдэнд харагдахаар илэрхийлж хэлдэг. Энэ тухай профессор Чой.Лувсанжав “Энгийн арав хорин үгээр гаргах санааг ганц хоёрхон үгэнд хураагаад хүний ой ухаанд тов тод оруулж өгөх ид чадал чухамхүү, хэл хэлний өвөрмөц хэллэгт байдаг юм” гэжээ.

Хоёр буюу түүнээс дээш бодит утга бүхий хэд хэдэн үг нийлж нэг утга санаа илэрхийлэхийг хэлц үг гэнэ.

**Жишээ нь:**

“халуун чулуу долоох” гэсэн үгийг бүрдүүлж буй гурван үгийн ганц ганцаараа байхдаа илрүүлж байсан утга нь үгүй болоод сая гурвуул нийлж “хашир”, “хал үзсэн” гэсэн нэгэн утга санааг илрүүлэн гаргах ба аль нэг үгийг нь өөр үгээр сольж огт болохгүй байна.

**Жишээ нь:**

“Нүд унагах, нүд халтирах, ам алдах, хөл алдах, хөл нь газар хүрэхгүй, хэрээ галуу дуурайж хөлөө хөлдөөх, эх нь булингартай бол адаг нь булингартай, тамаа цайх, гар бариад бугуй барих, шар нар бор хоног, суусан газраасаа шороо атгах, ам алдвал барьж болдоггүй, агт алдвал барьж болдог” гэх мэт нь цөм хэлц үг болно.

Орчин цагийн монгол хэлний хэлц үгийг найруулгын үүргээр нь бичгийн хэлний, найруулга дундын, ярианы хэлний хэлц үг гэж ангилан хувааж болно. Энэ нь найруулгыг дээд, дунд, доод гэж хуваадагтай зарим талаар адил байж болох юм. Өөрөөр хэлбэл, эрхэмсэг ярианы, энгийн ярианы, хар ярианы найруулга гэж болно.

**Бичгийн хэлний:** бүсээ чанга бүслэх (өлсөх), насны эцэст (өтөлсөн үед), хувь заяаны төөргөөр, ~ эрхээр (амьдралын жамаар), гарсан өдрийн гариг, төрсөн өдрийн төөрөг (ямар од гариг тохиох үед төрснөөр), нас нөхчих (үхэх), номын дуу сонсох (эрдэм ном сурах), өрхийг чанга (шинэ барилга, байгууламжийг ашиглалтад оруулах), хүйтэн дайны жилүүд (капитализм, социализмын үзэл суртлын жилүүд), эцсийн замд нь үдэх (оршуулах) гэх мэт.

**Найруулга дундын:** гар дүрэх (завших, хулгайлах), зүрх үхэх (шантрах), нас барах (үхэх), хөл алдах (баярлах), хоёр гар гаргах (сайн муу ялгаатай хийх), хэл ам гаргах (маргалдах), шав тавих (а. тэмдэг тавих, б. ёслол хийх), шүд зуух (хичээх, заных) гэх мэт.

**Ярианы хэлний:** насны бөгсөнд (нас ахисан үед), ам уралдуулах

(өрсөж ярих), амандаа орсон үгээ хэлэх (хамаагүй хэлэх, чалчих), давсанд явах (унтах), дүүрсэн хэрэг дөмбийсөн толгой (дууссан хэрэг, юугаа ч мэдэхээ байсан хүн), өөдөө хаясан чулуу өөрийн толгой дээр (хийсэн үйл нь эргээд тохиох), өрөөсөн дугуй (муу үйлээрээ адил), чад хийх (үхэх), хурган дарга (бага тушаалын дарга), хүзүү дутуу (чадлаар дутуу), их идсэн ч өмхий, бага идсэн ч өмхий (ямар ч үйл хийсэн адил) гэх мэт.

Хэлц үгийг нэг үе сонин хэвлэлийн найруулгад төдий л хэрэглэдэггүй байсан. Одоо үед сонин хэвлэлд нийгмийн өөрчлөл, хэвлэн нийтлэх эрх чөлөөтэй холбоотой өгүүлж буй зүйлээ хурц тод илэрхийлэх, сонирхолтой болгох, уншигчдын анхаарлыг татах зорилгоор хэлц үгийг ихээр хэрэглэх болсон байна.

**Жишээ нь:**

“Тэр тусмаа ...олон сар нойр хугаслан байж бэлтгэсэн “цайны ганц”-ыгаа өрсөлдөөнөөс шууд тахимыг нь өргүүлсэн явдал нь ардаа тохиролцоотой байж мэдэх аж” гэхэд тухайн өгүүлбэрт “нойр хугаслах”, “тахимыг нь өргүүлэх”, “цайны ганц” зэрэг өвөрмөц хэлцийг уншигчдын анхаарлыг татахын тулд ёгт өнгө аясаар хэрэглэжээ. “Цайны ганц” (гоёлын ганц хувцас) гэсэн утгатай хэлц үгийг энд “өөрийн ганц хүн” гэсэн утгаар хэрэглэсэн байна. Ийн хэлц үгийн утга өргөжин тэлдэг байна.





# ӨГҮҮЛБЭРИЙН НАЙРУУЛГЫН ОНЦЛОГ

Бодол санаагаа хэл зүйн хувьд зөв илэрхийлэх нь үг хэллэгийг оновчтой сонгож, үгийн байрыг ёс журмын дагуу оноон байрлуулахтай нягт уялдана. Ийнхүү үгийн дэс дараа, үгийн утгын зохицолдоог тохируулж хэрэглэх нь утга зохиолын хэлний хэм хэмжээг баримтлахын зайлшгүй чухал нөхцөлийн нэг болно.

*Харьцангуй утга төгссөн мэдээллийг бие биедээ илэрхийлэх хэлний хамгийн боломжтой бүтэц, хэлбэр нь өгүүлбэр юм.*

Өгүүлбэрийн гол амин сүнс нь үйл үгээр илэрдэг гэж үздэг. Хүний толгойд уг үйл явдлын тухай санаа төрмөгц хамаг анхаарлаа өгүүлэхүүнд төвлөрүүлдэг. Иймд өгүүлбэрийг найруулахад гол үүрэгтэй үгс бол үйл үг байдаг. Үйл үг бүхэн өмнөх гишүүнээ тодорхой хэлбэрээр захирдаг.

**Жишээ нь:**

“ав” гэсэн үйл үг “хэн” гэсэн үйлийн эзэнтэй харьцахаас гадна “юуг”, “хэнээс”, “юугаар” гэсэн хэлбэрийг захирч байна. Эдгээр хэлбэрийн аль нэгийг өөрчилбөл өгүүлбэрийн найруулга буруу болно.

## Өгүүлбэрийн гишүүдийн байрлал.

Өгүүлбэр сайн найруулах үндсэн нөхцөл нь гишүүдийг оновчтой, зөв холбон байрлуулах явдал юм. Ийм учраас өгүүлбэрийн утга санааг ойлгомжтой тодорхой илтгэн гаргая гэвэл гишүүдийг нь зөв байрлуулах хэрэгтэй.

Монгол хэлний өгүүлбэрийн гишүүд субъект, объект, предикат буюу өгүүлэгдэхүүн-тусагдахуун-өгүүлэхүүн гэсэн үндсэн дарааллаар бүтдэг. “Субъект” нь “тухайн үйлийг үйлдэж байгаа юм”, “предикат” нь “үйл хөдлөл”, “объект” нь “үйлд өртөж байгаа юм”-ыг заасан утгатай.

Монгол хэлний өгүүлбэрийн гишүүдийн байршлыг ерөнхийдөө тогтвортой гэж хэлж болно. Тэгэхдээ ихэвчлэн өгүүлэгдэхүүний бүлэг нь эхэндээ, өгүүлэхүүний бүлэг нь сүүлдээ байрладаг. Тодотгол гишүүн ямагт тодотгуулагчийнхаа өмнө, тусагдахуун, үйлийн тодотгол, зорилго,

шалтгааны байц холбогдох үгийнхээ өмнө байна. Харин орон, цагийн байц нэлээд чөлөөтэй байрлах боловч их төлөв өгүүлэгдэхүүний өмнө орно.

**Жишээ нь:**

“2015 оны 11 дүгээр сард Улаанбаатар хотод чөлөөт бөхийн барилдааны Дэлхийн цомын төлөө тэмцээн болов” гэхэд цаг заасан “2015 оны 11 дүгээр сард”, орон заасан “Улаанбаатар хотод” гэсэн гишүүд утгаараа зөвхөн үйлэнд биш, бүх өгүүлбэрт хамаатай учир эхэнд орсон байна.

Өгүүлэгдэхүүн их төлөв өгүүлэхүүний өмнө байх боловч ярианы хэл, яруу найраг зэрэгт өгүүлэхүүний дараа орох нь бий.

### **Өгүүлбэрийн холбоц.**

Сэтгүүлзүйн хэл найруулгын хамгийн гол зарчим бол хэллэг тод, цэвэр оновчтой, энгийн байх явдал юм. Энэ шаардлагыг хангахын тулд өгүүлбэр найруулах ухааныг сайтар эзэмших учиртай. Монгол хэл үг холбохын хувьд баялаг хэлний нэг бөгөөд найруулах, хамжуулах, аялга, дэс дараагаар холбох, үг давтах, үг хослох буюу хорших зэрэг олон янзын арга хэрэглэх өргөн боломжтой. Гэвч эдгээрийн дотроос хамгийн түгээмэл нь найруулах ба хамжуулах арга болно.

Үг, холбоо үгийг эх хэлнийхээ хууль зүйгээр зөв холбож нөхцөлдүүлбэл сая өгүүлбэр болох бөгөөд утга санаагаа бүрэн, зөв илэрхийлсэн өгүүлбэрүүдийн учир зүйн холбоо авцалдааг зөв олж холбож чадвал бичиж байгаа зүйл (эх) зөв болно. Иймээс өгүүлбэр бүрийг зөв найруулах нь бүтээл алдаа мадаггүй болохын үндэс суурь болдог байна.

Өгүүлбэр хураангуй, дэлгэрэнгүй (урт, богино), энгийн нийлмэл гэх мэт олон янз бүтэц бүрэлдэхүүнтэй, нэр үйл, энгийн, нийлмэл гэх мэт олон янз өгүүлэхүүнтэй байх тусмаа унших сонсоход нийцтэй байдаг.

Сэтгүүлзүйн бичвэрт дан болон нийлмэл өгүүлэхүүн зонхилж байна.

#### **а) Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэрийг найруулах нь**

Нийлмэл өгүүлбэрийн хамгийн энгийн хэлбэр нь Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр (ЗНӨ) юм. Нэг нь нөгөөдөө захирагдалгүй харилцан эрх тэгш орсон өгүүлбэрүүдийг

- А. Нэгдүгээр бүлгийн нөхцөл үйлээр
- Б. Холбоос үгээр
- В. Хэлэх аялгаар холбосныг ЗНӨ гэдэг.

ЗНӨ хэдэн ч энгийн өгүүлбэрээс бүтсэн байж болохоос гадна өгүүлбэрүүдийн хэмжээ урт богино буюу хураангуй дэлгэрэнгүй ямар ч байж болно.

ЗНӨ хэдийгээр эрх тэгш харилцан зэрэгцсэн харьцаатай байх боловч нэг өгүүлбэр нь нөгөөгийнхөө шалтгаан болсон учир зүйн дараалалтай байвал байрыг нь сольж болохгүй.

**Жишээ нь:**

“Би номоо уншиж, дүү тоогоо бодов.” гэхэд би ч ном уншсан, дүү ч тоо бодсон тул нэг нь нөгөөгийнхөө шалтгаан болохгүй учраас “Дүү тоогоо бодож, би номоо уншив.” гэж болж байна. Ийм үед ЗНӨ-ийн аль нь өмнө хойноо орох нь “нэмэгдэхүүний байр солиход нийлбэрийн чанар өөрчлөгдөхгүй” гэдэгтэй утга чанар адил байна. Гэтэл “алтан нар гийж, мөнгөн цасыг хайлууллаа.” гэхэд нар гийснээс цас хайлсан учир зүйн холбоо байх тул “Мөнгөн цас хайлаад, алтан нар гийлээ.” гэж болохгүй.

Иймээс ЗНӨ-ийг нэгдүгээр бүлгийн нөхцөл үйлээр холбоход өгүүлбэрийн учир зүйн дарааллыг зөв баримталсан цагт найруулга зөв болно. ЗНӨ-ийн өмнөх нь дараагийнхаа бүтэх нөхцөл шалтгаан болсон үед нэгдүгээр бүлгийн нөхцөл үйлийг нөгөөгөөр нь сольж болохоос гадна 2-р бүлгийн зарим нөхцөл үйлээр солин найруулахад утга өөр болохгүй.

### **б) Угсарсан нийлмэл өгүүлбэрийг найруулах нь**

Угсарсан нийлмэл өгүүлбэрт нэг өгүүлбэр нь нөгөөдөө гишүүний үүргээр холбогддог учир гишүүн өгүүлбэрийн өгүүлэгдэхүүний хэлбэр өөр болдог. Тиймээс энгийн өгүүлбэр, нийлмэл өгүүлбэрийг найруулахаас илүү ярвигтай. Сэтгүүлзүйн бичвэрт угсарсан нийлмэл өгүүлбэрийг аль болох цөөн хэрэглэхийг зөвлөж байна.

Угсарсан нийлмэл өгүүлбэрийн давуу тал нь хэд хэдэн энгийн өгүүлбэрийг холбож, олон энгийн өгүүлбэрийг ижил төгсгөлтэй болгохоос зайлсхийх боломж олгодог юм.

Жишээ нь:

“Энэ үед Болд сэмхнээр нүд дохисонд Балгармаа даруй учрыг мэдэж, морио гуядан одсонд Болдыг хөтөлж явсан нэг хүнээс бусад хоёр нь хойноос нь хөөсөн боловч Балгармаагийн морь сая барьж унасан тул цахилгаан мэт гялалзан далд оров” гэсэн өгүүлбэрт 6 энгийн өгүүлбэр нөхцөлджээ. Энэ 6 өгүүлбэрийг тус тусад нь утга төгсгөвөл “Энэ үед Болд сэмхэн дохив. Тэгэхэд Болдыг нэг хүн хөтөлж явав. Тэр нэг хүнээс бусад хоёр нь хойноос нь хөөв. Гэвч Балгармаагийн морь сая барьж унасан морь байв. Тийм учраас цахилгаан мэт гялалзан далд оров” гэсэн байдалтай болох бөгөөд бүх өгүүлбэр нь ижил төгсгөлтэй болохоос гадна өгүүлбэрүүдийн дунд “тэгэхэд, тэр, гэвч, тийм учраас” гэсэн холбоос үг давтагдах учир түрүүчийнхээс найруулга муу болж байна.

Сэтгүүлзүйн бичвэрт бусдын хэлсэн үгийг эш татан бичих, ярих зайлшгүй шаардлагатай байдаг.

Жишээ нь:

“Суут яруу найрагч Д.Нацагдорж эртний монголын сургаал үгийг шинэчлэн “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүн тийнхүү эрдэнийг өвөртөлж харина” гэж яруу сайхан хэлсэнбайдаг” гэсэн өгүүлбэрийн “Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү тийнхүү эрдэнийг өвөртөлж харина” гэсэн нь хөндлөнгийн үг, “Суут яруу найрагч Д.Нацагдорж эртний монголын сургаал үгийг шинэчлэн яруу сайхан хэлсэн байдаг” гэсэн нь өгүүлэгч (зохиогч)-ийн үг, “гэж” гэдэг нь хөндлөнгийн үгийг холбосон холбоос болно.

Хөндлөнгийн үгийг өгүүлж бичиж байгаа зүйлдээ аль болохоор нягт, учирзүйн нарийн авцалдаатай болгоход зохиогчийн үгийг зөв найруулах нь чухал юм.

# СЭТГҮҮЛ ЗҮЙН БИЧЛЭГИЙН ЗАРИМ ТӨРЛИЙН НАЙРУУЛГЫН ОНЦЛОГ

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн нийтлэл, нэвтрүүлэг нь тогтвортой шинж тэмдэг бүхий тодорхой хэлбэрээр оршиж байдаг бөгөөд сэтгүүл зүйн хөгжлийг дагаад байнга хөгжиж, баяжиж байдаг онцлогтой юм.

Бодит байдлыг тусгах хэлбэрийн мөн чанар болон бүтэц зохиомжийн нь шинж тэмдэг дахин давтагддаг тийм тогтвортой байдлыг бичлэгийн төрөл буюу жанр гэж нэрлэнэ.

Сэтгүүлзүйн бичлэгийн төрлүүдийг гүйцэтгэх үүрэг, зорилго, объектыг хамрах хүрээ зэрэг шинж чанарыг харгалзан мэдээ, ярилцлага, сурвалжилга, асуудал дэвшүүлсэн өгүүлэл, хөрөг гэсэн үндсэн төрөл зүйлд хуваадаг бөгөөд мөн эдгээр нь дотроо нарийн төрөл зүйлд задардаг байна. Бичлэгийн төрлүүд олон шинж тэмдгээр хоорондоо нийтлэг, бас ялгаатай байдаг.

Нийтлэг шинжүүд:

1. Бүх бичлэгийн төрөл эцсийн зорилгоор ижил төстэй байдаг. Өөрөөр хэлбэл, бүгд сэтгүүл зүйн өмнөө тавьсан зорилгоо биелүүлэх, ОНМХ-ийн үндсэн үүргүүдийг гүйцэтгэх эцсийн зорилго агуулдаг.

2. Бичлэгийн төрлүүд сэтгүүл зүйн үндсэн зарчмуудыг баримталдаг шинжээрээ нийтлэг юм.

3. Сэтгүүлчийн болон бусад бичигчийн уран чадварын шалгуур болдог онцлог нь бүх төрөл зүйлд адил байдаг.

4. Бүх бичлэгийн төрөл зүйл тухайн нийтлэл, нэвтрүүлгийн агуулга хэлбэрийн нэгдэл болдог шинжээрээ ижил төстэй юм.

Ялгаатай талууд:

1. Тусгаж буй объектын шинж чанар
2. Сэдвийн хамрах цар хүрээ, хэмжээгээр
3. Зохиогчийн өмнөө тавьсан зорилгоор
4. Бичлэгийн арга барилаар
5. Бүтэц зохиомжоор
6. Хэл найруулга, бичлэгийн өнгө аясаар тус тус ялгардаг.

Сэтгүүлзүйн бичлэгийн төрөл зүйл бүрийн хэл найруулга ялгаатай байхын дагуу өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг.

## Мэдээний хэл, найруулгын онцлог

### Товч, тодорхой

Сонин, телевиз, онлайн мэдээллийн хэрэгслийн алинд ч бай, товч, ойлгомжтой өгүүлбэрээр бичиж, мэдээг аль болох ойлгомжтой болгох нь чухал. Буруу ойлголт төрүүлж болзошгүй аливаа үг, өгүүлбэрээс зайлсхий. Ингэхийн тулд аль болох богино өгүүлбэрээр бичихийг зөвлөж байна.

### Өгүүлбэр хэр урт байх вэ?

Мэдээний өгүүлбэр хэдэн үгнээс бүрдсэн байх ёстойг тодорхойлох ямар нэгэн тогтсон дүрэм байхгүй. Гэхдээ 25-аас илүү үгнээс бүтсэн өгүүлбэр хэт урт сунжруу болох эрсдэлтэйг санаж байхад илүүдэхгүй. Товч өгүүлбэрээр бичиж сурвал алдаа гаргах магадлал эрс багасахаас гадна бичсэн зүйл тань илүү ойлгомжтой байх нь дамжиггүй. Өгүүлбэр тань хангалттай товч, энгийн, ойлгомжтой байгаа эсэхийг шалгахын тулд тухайн өгүүлбэрт хичнээн санаа багтсаныг тоолж үзэж болно.

Дараах хоёр жишээг харьцуулж үзээрй. Нэгдүгээр жишээнд нэг өгүүлбэрт бүх санаагаа багтаах гэж оролдсон бол хоёрдугаар жишээнд санаа бүрийг салгаж, гурван бие даасан өгүүлбэр болгосныг анзаараарай.

#### Жишээ 1:

Өнгөрсөн долоо хоногт орон нутгийн онгоц хөөрөхдөө А хотын ойролцоо цахилгааны шугам мөргөж осолдсоны улмаас нисэгч болон нислэгийн багийн дөрвөн гишүүн, машинаар зорчиж байсан гурван хүн амиа алджээ.

#### Жишээ 2:

Өнгөрсөн долоо хоногт А хотын ойролцоо онгоц осолдсоны улмаас найман хүн амиа алджээ. Орон нутгийн нислэг үйлдэхээр хөөрч байсан онгоц цахилгааны шугам мөргөсний улмаас нисэгч болон нислэгийн багийн дөрвөн гишүүн нас барсан байна. Онгоц унахдаа онгоцны буудлын ойролцоо явж байсан машиныг мөргөж, гурван зорчигч мөн нас баржээ.

Хоёр дахь жишээнд илүү олон үг орсон хэдий ч, санаанудыг гурван өгүүлбэрт хувааж, өгүүлбэр тус бүрийг илүү товч болгосныг анзаараарай. Эдгээр хоёр жишээг чангаар уншиж үзнэ үү. Товч өгүүлбэрүүдээс бүрдсэн хоёр дахь мэдээг ойлгоход илүү хялбар байгаа биз?

Үүний шалтгаан нь маш энгийн. Эхний жишээнд нэг өгүүлбэрт зургаан санааг багтаах гэж оролдсон байна. Уншигч үүнийг нэг амьсгаагаар хүлээн авч, ойлгох нь тийм ч амар биш.

1. Онгоцонд байсан хүмүүс
2. Машинд байсан хүмүүс
3. Онгоцны тухай мэдээлэл
4. Ослын шалтгаан
5. Осол болсон газрын тухай мэдээлэл
6. Үйл явдлын хугацаа

Хоёр дахь жишээнд нэг өгүүлбэрт аль болон цөөн санааг багтаасан байна. Эхний өгүүлбэрт дөрвөн энгийн мэдээллийг багтаажээ:

1. Осол хэзээ болсон
2. Хаана болсон
3. Нас барсан хүний нийт тоо
4. Нас барсны шалтгаан

Хоёр дахь өгүүлбэрт:

1. Онгоцонд байсан хүний тоо
2. Осолдсон онгоцны тухай мэдээлэл
3. Ослын шалтгаан

Гурав дахь өгүүлбэрт:

1. Машинд байсан хүний тоо;
2. Машин хаана явж байсан
3. Машин яагаад осолдсон

тухай мэдээллийг өгчээ. Хоёр дахь жишээ илүү урт болж, илэрхийлж буй санааны тоо нь зургаа биш, арав болсныг та анзаарч буй байх. Хамгийн гол нь нэг өгүүлбэрт багтсан санааны тоо харьцангуй цөөн учир ойлгоход илүү хялбар байгаа юм. Бие даасан өгүүлбэр нь уншигчид дараачийн өгүүлбэр хүртэл амьсгаа авч, хүлээн авсан мэдээллээ тархиндаа боловсруулах хугацааг өгдөг.

Тиймээс нэг өгүүлбэрт гурваас илүүгүй санаа багтааж байхыг зөвлөж байна. Дээр дурдсан хоёр дахь жишээний эхний өгүүлбэрт дөрвөн санаа багтсан байна гэж та хэлэх байх. Осол хэзээ, хаана болсон тухай мэдээлэл бол маш энгийн, ойлгоход хялбар учир зарим товч өгүүлбэрт дөрвөн маш энгийн санааг багтааж болохыг дээрх жишээ харуулж буй юм.

## Мэдээг хэрхэн амьд болгох вэ?

Мэдээ зөвхөн баримтанд тулгуурлах ёстой. Мэдээ бичиж буй сэтгүүлч дүрслэл, зураглал, үзэл бодол, уянгын халил хэрэглэх учиргүй. Зарим залуу сэтгүүлч энгийн товч мэдээ бичихдээ уран яруу үг хэллэг ашиглаж, мэдээлж буй зүйлд өнгө нэмж, хүч оруулах гэж хичээдэг.

### Жишээ нь:

Тэрээр замын эсрэг тал руу хар эрчээрээ гүйж очин зэрлэгээр зодуулж байсан дорой хүүд тусалжээ.

Өгүүлбэрт орсон тэмдэг нэрүүд бичигчийн үзэл бодол, хувийн дүгнэлтийг шингээснээс гадна өгүүлбэрийг илүү энгийн, ойлгомжтой болгоход тус болохгүй байгааг анзаараарай. Учир нь эдгээр тэмдэг нэрийг хасаад уншихад өгүүлбэрийн утга санаа алдагдахгүй, харин илүү товч ойлгомжтой болно. Тэрээр замын эсрэг тал руу гүйж очин зодуулж байсан хүүд тусалжээ.

Мэдээг амьд болгохын тулд өгүүлбэрт тэмдэг нэрээр хүч оруулах бус, харин үйл үгийг нөхцөл байдалд тохируулан зөв сонгох нь чухал. Жишээлбэл гүйх, алхах, сажлах, гэлдрэх, мөлхөх гэх мэт үгийг сонгож, болсон явдлыг тод томруунаар харуулах боломжтой. Үйл үг ч үзэл бодол илэрхийлдэг учир сонгосон үйл үг тань бодит үнэнд нийцэх ёстой бөгөөд хүч оруулах зорилгоор мушгин гуйвуулж болохгүй.

Мэдээг амьд болгох нэг боломж бол ишлэл ашиглах явдал юм. Сэтгүүлч өөрөө болсон явдлыг дүгнэж болохгүй ч, оролцогчдын өөрсдийн үгээр тэдний дүгнэлтийг дамжуулах боломжтой.

Тухайлбал гэмт хэргийг сэжигтэн болон хохирогчийн өмгөөлөгч өөр өөрийн байр сууринаас дүгнэж буй дараах ишлэл харуулж байна:

Хохирогчийн өмгөөлөгч:

"Өөдгүй хулгайчид гэмгүй айлд ямар ч шалтгаангүйгээр халдсан"

Сэжигтэн:

"Би дээрэмдээгүй. Би баян хүний илүү зүйлийг нь авч ядуу хүнд л өгсөн."

## Үйл үгийн идэвхтэй хэлбэр ашигла

Мэдээ ихэвчлэн болсон үйл явдлын тухай товч мэдээлэл өгөхийг зорьдог. Ялангуяа мэдээний гарчигт болж өнгөрсөн, эсвэл болох гэж буй зүйлийн гол санааг илэрхийлэх нь элбэг.



Ингэхдээ сэтгүүлчид үйл үгийн идэвхтэй хэлбэрийг ашиглавал илүү ойлгомжтой, энгийн бичиж, хэл найруулгын алдаа гаргахаас зайлсхийх боломжтой.

Буруу \_\_\_\_\_

Уралдаан зохион байгуулагдав.  
Сургалтыг эхлүүллээ.  
Төсөл өргөн баригдав  
Зохион байгуулалт хийв  
Уншилт явагдав

Зөв \_\_\_\_\_

Уралдаан зохион байгуулав  
Сургалт эхэллээ  
Төсөл өргөн барив  
Зохион байгуулав  
Уншив

### Энгийн өгүүлбэрээр бич

Мэдээг товч, ойлгомжтой бичихийн тулд аль болох энгийн, эсвэл энгийн нийлмэл өгүүлбэрээр бичихийг зөвлөж байна. Сэтгүүлзүйн мэдээ нь “чухал мэдээллийг эхлээд мэдээлэх” зарчимд захирагддаг. Тийм ч учраас чухал зүйлд уншигчийн анхаарлыг хандуулахын тулд “учир”, “боловч”, “хэдийгээр” гэх мэт үгээр холбосон нийлмэл өгүүлбэрээс зайлсхийх нь зүйтэй.

Жишээ нь: \_\_\_\_\_

8 дугаар сарын сүүлээр замын ачаалал ердийнхөөс хоёр дахин ихэсдэг учир 9 дүгээр сарын сүүлийн амралтын өдрүүдэд машины дугаар хязгарлах болов. Түрүүлж мэдээлэх ёстой чухал санаа нь 9 дүгээр сарын сүүлийн амралтын өдрүүдэд машины дугаар хязгаарлах болсон тухай юм. Тиймээс энэ өгүүлбэрийг хоёр энгийн өгүүлбэр болгож, түрүүлж мэдээлэх ёстой чухал зүйлд гол анхаарлыг дараах байдлаар хандуулна.

Зүй нь: \_\_\_\_\_

9 дүгээр сарын сүүлийн амралтын өдрүүдэд машины дугаар хязгаарлах болов. Учир нь 8 дугаар сарын сүүлээр замын ачаалал ердийнхөөс хоёр дахин ихэсдэг аж.

### Ярилцлагын хэл найруулгын онцлог

Сэтгүүлзүйн бичлэгийн бусад төрөл зүйлээс хамгийн албан ёсны бус, чөлөөтэй, урьдчилан бэлтгээгүй хэл найруулгыг ярилцлагад ашигладаг. Ярилцлагад өдөр тутмын ахуй амьдрал, аж байдлын харилцаанд тохиолддог, харилцан ярианы бүтэцтэй найруулгыг ашиглана. Өөрөөр хэлбэл ярианы найруулгаар бичлэгийн энэ төрөл зүйлийг бүтээнэ.

Ярианы найруулга нь гудамны хар ярианы хэл биш бөгөөд харин бичгийн хэлний нэг төрөл юм. Ярианы найруулгаас аман бичгийн ярианы найруулгыг сэтгүүлзүйн ярилцлагын төрөл зүйлд илүү ашигладаг. Аман бичгийн яриа нь олон нийтийн дундын шинжтэй байдаг бөгөөд сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл ч нийт хүмүүст зориулсан байдаг.

Ярианы хэлийг хамгийн өргөн дэлгэр тусгадаг нь ярилцлага юм. Учир нь бичлэгийн энэ төрөл зүйл харилцан ярианаас бүрдэх бөгөөд мэдээллийн утга санаанаас гадна ярилцагчийн дүрийг амилуулах боломж зөвхөн ярианы хэлэнд бий. Ярианы хэл ярилцлагыг илүү чөлөөтэй, илүү амьд, илүү халуун дулаан уур амьсгалтай болгодог. Учир нь хэл бол харилцахаас гадна харилцааг илүү халуун дулаан болгох үүрэгтэй.

Хэл бол нийгмийн шинжтэй боловч тухайн хэлээр ярьж хэлэх нь хувийн шинжтэй байдгаараа онцлог. Энэ онцлогыг ярианы хэл илэрхийлж чадна. Ярилцлагад хэлэх зүйлийг урьдчилан бэлтгэдэггүй. Өмнөөс зориуд сонголт хийж төлөвлөхгүй. Бичгийн хэлнийх шиг нарийн чамбай байдаггүй. Түүнчлэн ярианд дохио зангаа нүүрийн хувирал, үгийн утгын өргөлт, өнгө аялга, хурд чухал байдаг. Сэтгүүлч энэ бүхнийг харгалзаж утга агуулгыг уншигчдад бүрэн дүүрэн хүргэх шаардлагатай болно. Тэгэхийн тулд бүрэн бус буюу дутмаг өгүүлбэр их хэрэглэнэ. Ярилцагч өгүүлбэрээ дутуу төгсгөх нь элбэг байдаг. Өгүүлбэрийн гишүүдийн байрлал буюу дэс дарааллыг чөлөөтэй өөрчлөдөг. Ярилцагчийн сэтгэлийн хөдөлгөөн их илэрдэг тул хандсан үг, оруулсан үг, яриа зонхилдог.

Ярилцлагад орж буй үгийн сангийн онцлог нь бичгийн хэлнээс өөр. Өөрөөр хэлбэл ярианы хэл өөрийн гэсэн үгийн сантай.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

цаас(ярианы хэл), төгрөг (бичгийн хэл)...

Гэхдээ ярианы хэл гээд амар хялбар байна гэсэн үг биш.

Тухайлбал, ярилцагчийн дүр төрх, зан авир, ярилцлагаар хөндөж буй сэдвээс хамаарч хэлний яруу хэрэглүүрийг ч хэрэглэх шаардлага гардаг. Ялангуяа хэлц үгийг элбэг ашигладаг.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

За гэвэл ёогүй, Хоёрын хооронд...г.м

Мөн ярилцлагын үеэрх уур амьсгал, нөхцөл байдлыг уншигчдад мэдрүүлэхийн тулд ярианы үг үүсгэдэг олон дагавар ашигладаг.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Сэтгэлийн аяс илэрхийлэх –хан4 дагавар түгээмэл байдаг.

Бүрмөсөн үйлдэх байдлын “–чих”, эрчимтэй үйлдэх байдлын

“-схий” дагаврууд олон хэрэглэгддэг.

Тухайн үйл явдлыг төгс илэрхийлэхдээ урьдчилан холбох “-аад” нөхцөл ба “орхи” гэсэн үгийн нийлцээс үүссэн “-аадах, -ээдэх, өөдөх, -оодох” гэсэн бүтцээр илэрхийлдэг.

Жишээ нь:

өгөөдөх-өгөөд орхи

Урьдчилах үйлийн тийн ялгал -аад4

Олноор үйлдэх байдлын -цгаа4

Байдлын дагавар давхарлана знасхий-

### **Өгүүлбэр зүйн хувьд ярилцлага дараах онцлогтой байдаг**

Энгийн өгүүлбэрээр ихэвчлэн найруулна. Нийлмэл өгүүлбэр дотроос хэлэх аялгаар холбогдсон ЗНӨ зонхилдог. Сэтгэлийн хөдөлгөөн аясыг илэрхийлэх аялга үг, өгүүлбэр элбэг байна. Жишээлбэл, Пөөх, Паах, Хүүе гэх мэт. Нэгэнт яриаг урьдчилан төлөвлөдөггүй учраас өгүүлбэрийн гишүүдийн байр нь төдийлөн тогтвортой биш.

Мөн харилцан хоршил яриа их байна. Хэв шинж нь асуусан, анхааруулсан сул үг. Нэг бүрэлдэхүүнт өгүүлбэрийг түгээмэл ашиглана. Сэтгэл хөдлөл илтгэсэн үг ихтэй. Үг давталт, үгийн давхцал ихтэй. Тоочсон, оруулсан үг хэллэг олон гэх мэт ярилцлагад аман ярианы өгүүлбэр зүйн өөрийн гэсэн онцлог байдаг.

Ярианы хэл нь бичгийн хэлнээс уян налархай хурдан хувьсаж хөгждөг. Бичгийн найруулгад үгийн байр зэргийг төдийлөн өөрчилж, гажуудуулж болдоггүй бол ярианы найруулгад үгийн байр дэс дарааг өөрчилж болохын хамт хэлний яриандаа юуг чухалчилж байгаагаа илэрхийлж болдог. Бичгийн найруулгад өгүүлбэрийн гишүүдийн байр тогтвортой байдаг бол ярианы найруулгад чөлөөтэй өөрчилж сэлгэх боломжтой.

### **Сурвалжилагын найруулгын онцлог**

Бичлэгийн бусад төрөлтэй харьцуулахад сурвалжилгын хэл найруулга нь хамгийн энгийн, ойлгоход хялбар, цөөн үгээр өргөн агуулга гаргадаг онцлогтой. Сурвалжилгын найруулга нь үйл явдлын өрнөлтэй нягт уялдан дагаж хүүрнэх хэлбэрээр бичдэг онцлогтой.

Харин энэхүү найруулгын нэгэн хэв маягаас уншигчид залхаж болзошгүй тул дүрслэлийн олон арга хэрэглүүрийг сэтгүүлчид ашигладаг. Учир нь сурвалжлагын гол бүрэлдэхүүн нь дүрслэл байдаг. Ажиглалтын аргаар олж авсан мэдээллээс тухайн сэдэв, өнцөгтэй холбоотой зүйлийг сонгон дүрслэл хийхийн тулд хэлний уран яруу хэрэглүүрийг зайлшгүй хэрэглэнэ.

Өгүүлж байгаа зүйлээ урнаар дүрслэхийн тулд үгийн утгыг шилжүүлэн дүрслэхийг утга шилжүүлэх яруу хэрэглүүр гэнэ.

Адилтгал, төлөөлөл, чимэг үг, зүйрлэл, орлуулал, тойруулал, амьдчилал, бэлгэдэл, ёгтлол, ихэсгэл, багасгал гэх мэт олон арга бий. Эдгээрээс сэтгүүлзүйн бичлэгийн төрөлд түлхүү хэрэглэдэг хэдэн аргыг авч үзье. Сурвалжилга гэдэг өөрөө баримтын тухай өгүүлдэг учраас ихэсгэл, багасгал, хүншүүлэх, ёгтлол гэх мэт яруу хэрэглүүрийн арга зохимжгүй юм.

**Чимэг үг:** Дүрсэлж байгаа зүйлийн бусдаас тод ялгарах чухал шинжийг хурцаар, маш тодорхой болгох зорилгоор хэрэглэдэг уран яруу тодотголыг чимэг үг гэнэ.

**Жишээ нь:**

ган зориг, мөнгөн саран, алтан наран, эмээлт морь, тоонот гэр,  
ургах наран гэх мэт.

Чимэг үг бүхий дүрслэл “... Хөх тэнгэрт алтан нар гялалзаж байлаа. Үрчгэр Алтайн баржгар хад арзайж миний сэтгэлийг гунихруулж байв. Наранд улайдсан хүрэн чулуу, бараан уулыг харсаар яваад нүд их чилж байлаа. Хүрэн хад уулын завсарт байгаа тэр хөх ус, ногоон зүлэг, цагаан чулуу гурвуул нийлж...”

/Ц.Дамдинсүрэн “Хоёр цагаан юм”/

**Зүйрлэл:** Юмс үзэгдлийн аль нэг шинжийг ялгаруулан тод томруун болгох зорилгоор өөр төстэй юм үзэгдэлтэй нь зэрэгцүүлэн тавьж дүрслэх найруулгын ур маягийг зүйрлэл гэнэ.

Зүйрлэлийн аргыг ашигласнаар уншигчдад тухайн зүйлийн талаар тодорхой төсөөлөл бий болгодог. Зүйрлэл бол хязгааргүй өргөн боломжтой найруулгын гол хэрэглүүр юм. Сэтгүүлчийн ур чадвар, сэтгэлгээний цар хүрээнээс хамаарч ямар ч зүйлийг зүйрлэх боломжтой. Жишээ нь: Хоёр хүн эвтэй болбоос төмөр хүрээ мэт бэх, Борвийг хазах өл буур мэт Бороот өдөр довтлох өлөн чоно мэт гэх мэт...

**Адилтгал:** Юм үзэгдлийн аль нэг шинжийг товойлгон тодруулах зорилгоор түүнтэй төстэй өөр юм үзэгдлийн нэрээр утга шилжүүлэн дүрслэх найруулгын ур маягийг адилтгал гэнэ.

Адилтгал бол далд зүйрлэл ч гэж ярьдаг.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Үүрийн гэгээ гэгээрэхэд хөмсөг мэт сар далд ороогүй... Өвгөн жолооч ухасхийн хийг нэмэхэд дөрвөн хүрд харвасан сум мэт эргэлдэх бөгөөд... Хасын өнгөт дөрвөлжин цагаан шүдээ яралзуулан үе үе инээмсэглэн мишээх нь хаврын улирал ирж буй адил бахдалтай... гэх мэт.

Энэ мэтээр юмсыг хооронд харьцуулж, адил төстэй зүйлээр нь нэрлэхдээ:

- Хэлбэр дүрс, хэмжээгээр нь адилтгах – майхан уул, үхэр чулуу, хонин гүрвэл, тэмээн хяруул
- Чанар, үнэ цэнээр нь адилтгах – алтан дэлхий, алтан амь, мөнгөн хурим
- Өнгөөр нь адилтгах – мөнгөн сар, танан гэр
- Үүргээр нь адилтгах – төрийн жолоо, амьдралын босго зэрэг олон арга бий.

“Үзэгдэл юмсыг танин мэдэх хүний үндсэн арга бол мэдэхгүй байгаа юмаа мэддэг юмтайгаа жишин үзэж түүнтэй төстэй хийгээд төсгүй байгаа шинжийг нь адилтган үзэж оюун дүгнэлт гаргадаг учраас адилтгах арга бол танин мэдэхүйн гол арга юм.” гэсэн байдаг. Дарамын Батбаяр “Бүтээхүйн зүй тогтол, сайхныг бүтээх нууц” Уб., 2008, 199 дэх тал.

**Төлөөлөл:** Шинж байдлаараа адил төсөөгүй боловч ямар нэг талаараа холбоотой хоёр үзэгдлийг тэмдэглэсэн хоёр үгийн нэгийг нөгөөгөөр нь орлуулан түүнд утгыг нь шилжүүлснээр товч бөгөөд уран яруу илтгэх хэрэглүүрийг төлөөлөл гэнэ.

Төлөөллийн төрлүүд: Агуулагдаж буй зүйлийг агуулж байгаа зүйлээр төлөөлүүлэх.

**Жишээлбэл:** \_\_\_\_\_

Хоёр таваг идэв. Гурван аягыг уув.

Юмны хэсгийн нэрээр бүхлийг төлөөлүүлэх.

**Жишээлбэл:** \_\_\_\_\_

Дөрвөн ам дагуулсан бас хөл хүнд амьтныг ...

Аливаа үйлийг хийсэн эзнээр нь төлөөлүүлэх.

Жишээлбэл: Нацагдоржийг унших гм.

Үйлийн эзнийг үйлээр нь төлөөлүүлэх. Жишээлбэл: Ухаа хонгор морьтой доо Улсын их жанжин даа Учир бүгдийг ухуулсан Ухаан ихтэй жанжин даа гэж Д.Сүхбаатарыг төлөөлүүлэх жишээтэй.

Тооны төлөөлөл буюу “түмний төлөө зүтгэх” гэдэг нь 10,000 хүний төлөө бус нийт олны төлөө гэсэн төлөөлөл юм.

Шинж чанараар нь төлөөлж болно. Шувуун саарал, Хурдан борлог, Толин хул гэх мэт.

Төлөөллийн нэг онцгой нарийн зүйл бол нэг юм үзэгдэл нөгөө юм үзэгдэлд утга шилжихдээ тооны харьцаагаар шилжиж буй тооны төлөөлөл юм. Тодруулбал, олны утгыг ганц тоогоор, ганцын утгыг олон тоогоор, бүхлийг хэсгээр, зүйлийг төрлөөр, төрлийг зүйлээр, ерөнхийг тусгайгаар, тодорхойг хийсвэрээр гэх мэт.

**Жишээ нь:** \_\_\_\_\_

Талхаар юу юу төлөөлүүлж болох вэ? Өдөр тутмын өл хоолыг талхаар төлөөлүүлж болно. Мөн өдөр тутмын амьжиргааг “талхны мөнгө” хэмээн хэлдэг.

Хэн нэгний зан чанар, хийсвэр шинжийг түүний үлгэр болсон тодорхой нэг хүн буюу бодгалийн дүрээр хэлэх хэлбэр байдаг. Жишээ нь: хартай эрийг Отелло, тачаангуй эрийг Дон Жуан, үймүүлэгчийг Хоролмаа, гэр бүлээ орхигчийг Шагдар ч гэх мэтээр төлөөлүүлж болно.

Энэ мэтээр сэтгэл хөдөлгөх уран үг, өвөрмөц хэллэг, хэлний яруу хэрэглүүрийг сурвалжилгад зохистой ашиглавал уншигчдад нөлөөлөх үр өгөөж төдий чинээ их болдог.

Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр түгээж буй үгийн найруулга нь үнэн магад, тодорхой баримт, бодит шалтгаан, нарийн үндэслэл зэрэг шинжээрээ бусад найруулгын төрлөөс ялгардаг. Тэгэхдээ сурвалжилгыг өргөн олон түмэнд зориулдаг болохоор хэл найруулгын хувьд нэн чухал шаардлага нь хамгийн ойлгомжтой байх ёстой.

Энэ бол эхийн түвшинд найруулгын чанарыг онцгой анхаарна гэсэн үг.

## Ашигласан номын жагсаалт

1. Монголын тогтмол хэвлэлийн хэл найруулга үгсийн сангийн өнөөгийн байдал судалгааны тайлан. Улаанбаатар. 2007 он.
2. Хэлний соёлын тулгамдсан асуудлууд. Улаанбаатар. 2002 он.
3. Г.Буянтогтох, Г.Давааням нар. Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар. 2009 он.
4. Д.Заяабаатар нар. Нийтээр эзэмших монгол хэл. Улаанбаатар. 2017 он.
5. Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулга зүй. Улаанбаатар. 2015 он.
6. Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулга зүйн нэр томъёоны тайлбар толь. Улаанбаатар. 2003 он.
7. Ц.Сүхбаатар. Найруулга зүйн дасгал. Улаанбаатар. 2011 он.
8. Ч.Чойсамба. Сонины хэл найруулга. Улаанбаатар. 2000 он.
9. Ц.Шагдарсүрэн. Эх хэлээ эвдэхгүй юмсан. Улаанбаатар. 2010 он.
10. Хэвлэлийн Хүрээлэн. Ярилцлага гарын авлага. Улаанбаатар. 2008 он.
11. Хэвлэлийн Хүрээлэн. Мэдээ гарын авлага. Улаанбаатар. 2015 он.